

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,
БОЛОВСРОЛЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2024 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/113, А/151

Улаанбаатар хот

Удирдамж батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.24 дэх заалт, 8.5 дахь хэсэг, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалт, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.10 дахь хэсэг, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.14-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн суралцагчдад нүд, шүд, зүрхний эмгэгийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулах удирдамж"-ийг нэгдүгээр, "Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг хийх аргачлал, зураглал"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн суралцагчдын урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгийн санхүүжилтийн зардлыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох тогтоолын дагуу санхүүжүүлэхийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар /М.Нармандах/-т даалгасугай.

3. Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн суралцагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгийн үйл ажиллагааг энэ тушаалаар батлагдсан хавсралтуудын дагуу зохион байгуулахыг анхан шатны эрүүл мэндийн байгууллага, өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн захирал, шүдний эмнэлгийн дарга нарт, үйл ажиллагааны хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар /Т.Ням-Очир/, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын болон Боловсролын газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн суралцагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгийн цахим бүртгэлийн мэдээллийн сан байгуулах, хадгалах, баяжуулах, ашиглах үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулахыг Эрүүл мэндийн яамны Стратеги, төлөвлөлтийн газар /П.Оюунцэцэг/, Боловсролын яамны Цахим боловсролын газар /Т.Бат-Эрдэнэ/ эрүүл мэндийн даатгалын мэдээллийн сангийн өгөгдөл солилцох ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар /М.Нармандах/-т тус тус үүрэг болгосугай.


5. Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн суралцагчдын шүдний эмгэгийн эрт илрүүлгийн үзлэг хийх шүдний эмнэлгийг Эрүүл мэндийн яамнаас гаргасан шалгуурт нийцүүлэн сонгон шалгаруулж, шалгарсан шүдний эмнэлгийг анхан шатны эрүүл мэндийн байгууллагатай, зүрхний эмгэгийн эрт илрүүлгийн үзлэг хийх анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг нарийн мэргэжлийн хүүхдийн зүрхний эмчтэй тус тус гэрээ байгуулах үйл ажиллагааг чанартай зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

6.Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн суралцагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг хийхэд шаардагдах хүний нөөцийг бүрдүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, сургуулийн эмч, ажилтнуудыг чадавхжуулах сургалт зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/, хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, бодлогын зохицуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Стратеги, төлөвлөлтийн газар /П.Оюунцэцэг/-т тус тус үүрэг болгосугай.

7.Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн суралцагчдын нүдний эмгэгийн эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулахад шаардагдах харааны хэрэглэгдэхүүнийг худалдан авахад шаардагдах зардал болох 60,314,250 (жаран сая гурван зуун арван дөрөв мянга хоёр зуун тавь) төгрөгийг тухайн жилийн сайдын хөтөлбөр арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Х.Батжаргал/-д, эрт илрүүлгийн үзлэгийг хийх хүний нөөцийг чадавхжуулах сургалтын болон бусад холбогдох зардлыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д холбогдох зардлаас санхүүжүүлэхийг тус тус зөвшөөрсүгэй.

8.Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн тайлан, мэдээнд дүн шинжилгээ хийж, нэгтгэн мэдээлэх, үйл ажиллагааны хэрэгжилтийг бодлогын удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газар /Л.Баттөр/, шаардагдах санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгуулан төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын газар /Л.Лувсан/, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Б.Батцэцэг/, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/, Боловсролын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Н.Нарангэрэл/ нарт тус тус даалгасугай.





Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын хамтарсан 2024 оны 12 дүгээр сарын 21-ны өдрийн 113-дугаар тушаалын нэгдүгээр хавсралт.

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 1 ДҮГЭЭР АНГИЙН СУРАЛЦАГЧДЫН НҮД, ШҮД, ЗҮРХНИЙ ЭМГЭГИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ҮЗЛЭГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ”

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Ерөнхий боловсролын сургуульд суурилсан эрүүл мэндийн эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулахад энэхүү удирдамжийг баримтална.
- 1.2. Сургуулийн насны хүүхдийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг (цаашид “Эрт илрүүлэг” гэх) нь хүүхдийн амь нас, амьдралын чанар, суралцах чадварт хохирол учруулах өвчнийг эрт үед нь илрүүлэх, түүнийг үр дүнтэй эмчилж, ирээдүйд учирч болзошгүй хүндрэл, нас баралт, санхүүгийн дарамт, суралцахад саад болох нөхцөл байдлаас сэргийлэх зорилготой.
- 1.3. Эрт илрүүлэг нь хүүхдийн эрсдэлт хүчин зүйлийг үнэлэх, эмнэл зүйн ерөнхий үзлэг хийх, хараа шалгах, нүдний үзлэг, амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг, зүрхний цахилгаан бичлэг хийх, дүгнэх, зүрхний хэт авиан шинжилгээ хийх, эмнэлзүйн дүгнэлт өгөх, зөвлөгөө мэдээллээр хангах, шаардлагатай тохиолдолд лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад оношийг тодруулахаар илгээх, хянах, эрүүл мэндийн боловсрол олгох цогц үйл ажиллагаа байна.
- 1.4. Эрт илрүүлгийг эрүүл мэндийн байгууллагын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал болон ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын хэвийн үйл ажиллагааг алдагдахгүйгээр сургуульд суурилан зохион байгуулна.
- 1.5. Энэхүү удирдамжийн 1.3-т заасан нүд, шүд, зүрхний эмгэгээс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгт нэгдүгээр ангийн суралцагч бүр хичээлийн жилд нэг удаа хамрагдана.
- 1.6. Эрт илрүүлэг нь төлбөртэй тусламж, үйлчилгээнд хамаарахгүй болно.
- 1.7. Төвлөлт хугацаанд хийгдсэн үзлэг, шинжилгээний хариу, дүгнэлтийг эрт илрүүлэгт хамрагдсанаар тооцож болно.
- 1.8. Эрт илрүүлгийн зохион байгуулалт, явц, үр дүнгийн талаар холбогдох эрүүл мэндийн байгууллага хэвлэл мэдээллийн байгууллагад мэдээлэл өгнө.

Хоёр. Эрт илрүүлгийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт

- 2.1. Сургуульд суурилсан эрүүл мэндийн эрт илрүүлгийг энэхүү удирдамжийн 3, 4-т заасан эрүүл мэндийн болон боловсролын байгууллага хамтран зохион байгуулна.
- 2.2. Эрт илрүүлгийн үйл ажиллагааг улсын хэмжээнд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн удирдлагаар хангана.
- 2.3. Боловсролын ерөнхий газар нь ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангийн суралцагчдын судалгааг эрт илрүүлэг зохион байгуулахаас нэг сарын өмнө аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт хүргүүлнэ.

2.4. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь энэхүү удирдамжийн 2.3-т заасан судалгааг нэгтгэж, эрт илрүүлэгт зохион байгуулахаас ажлын 5 хоногийн өмнө Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт хүргүүлнэ.

2.5. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь эрт илрүүлэгт хамрагдах хүүхдийн мэдээлэлд үндэслэн шүдний эмнэлэг, ерөнхий боловсролын сургуулийн төлөөлөл бүхий баг бүрдүүлж, энэхүү удирдамжийн 1.3-т заасан үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

2.6. Ерөнхий боловсролын сургууль нь эрт илрүүлэгт хүүхдийг хамруулахаас өмнө дараах бэлтгэлийг хангасан байна.

2.6.1. эрт илрүүлгийн үзлэгт хүүхдийг хамруулах талаар эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид үнэн зөв мэдээлэл өгч, холбогдох хуульд заасны дагуу тэднээс зөвшөөрөл авсан байх;

2.6.2. эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас бэлтгэсэн тухайн хүүхдийн өвчний эрсдэлийг тодорхойлох асуумжийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс авсан байх.

2.7. Эрт илрүүлгийн үйл ажиллагаа нь асуумж, үзлэг, шинжилгээ, оношилгоо, хяналт зэргийг багтаасан цахим бүртгэлийн системтэй байна.

2.8. Эрт илрүүлгийг зохион байгуулах багийг холбогдох сургалтад хамруулж бэлтгэсэн байна.

2.9. Энэхүү удирдамжийн 2.5-д заасан баг нь эрт илрүүлгийн тайлан, үр дүнг тухайн сургуулийн анги/бүлэг тус бүрээр гаргаж сургуулийн эмч (тухайн сургууль эмчгүй тохиолдолд сум, тосгон, багийн ерөнхий эмч)-д хүлээлгэн өгнө.

2.10. Энэхүү удирдамжийн 2.9-д заасан эмч нь эрт илрүүлгийн үр дүнг суралцагчдын эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд танилцуулж, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулна.

2.11. Ерөнхий боловсролын сургууль нь энэхүү удирдамжид заасан хүүхдийн эрүүл мэндийн мэдээллийг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн дагуу задруулахгүй байна.

2.12. Эрт илрүүлгээр өөрчлөлттэй гарсан тохиолдолд эмнэлгийн лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагад холбогдох журмын дагуу илгээнэ.

2.13. Онош тодруулахаар илгээсэн тохиолдлыг хүлээн авсан эмнэлгийн лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллага нь оношийг баталгаажуулан эргэн мэдээлэх бөгөөд цаашид авах арга хэмжээний талаар илгээсэн байгууллагад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

2.14. Онош баталгаажсан тохиолдолд онош тавьсан болон онош тодруулахаар илгээсэн эрүүл мэндийн байгууллага хариуцна.

2.15. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь өөрийн байгууллагад бүртгэлтэй хүүхдийн онош баталгаажсан тохиолдол, эмчийн хяналтад орсон мэдээллийг нэгдсэн цахим бүртгэлээс татан авч, дүн шинжилгээ хийх, хяналтад ороогүй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчтай холбоо барих, хяналтад орохыг зөвлөж, эмчлэх арга хэмжээг зохион байгуулна.

Гурав. Эрт илрүүлгийн тусламж үйлчилгээг улсын хэмжээнд зохион байгуулахад эрүүл мэндийн байгууллагын чиг үүрэг

3.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хүлээнэ:

3.1.1.эрт илрүүлгийн аргачлал, зааврыг олон улсын туршлага, нотолгоо, судалгаа, мэргэжлийн тэргүүлэх байгууллага, мэргэжлийн салбар зөвлөлийн саналыг үндэслэн гаргах;

3.1.2.эрт илрүүлгийн тусламж үйлчилгээний эмнэлзүйн заавар, удирдамжийг шаардлагатай тохиолдолд шинэчлэх;

3.1.3.эрт илрүүлгийн тусламж үйлчилгээнд шаардагдах хүний нөөц, багаж, тоног төхөөрөмжөөр эрүүл мэндийн байгууллагуудыг үе шаттай хангах;

3.1.4.эрт илрүүлгийн үйл ажиллагааны зохион байгуулалт, үр дүн, зардлын үр ашиг, эрүүл мэндийн салбарт үзүүлэх үр нөлөөг үнэлэх, судлах, хэрэгжилтэд хяналт тавих;

3.1.5.эрт илрүүлгийн цахим бүртгэлийн мэдээний сан байгуулах, хадгалах, баяжуулах, ашиглах үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулах, цахим системийг эрүүл мэндийн салбарын бусад цахим платформуудтай холбох.

3.2. Үндсэн мэргэжлийн төвүүд дараах чиг үүргийг хүлээнэ:

3.2.1.эрт илрүүлгийн үйл ажиллагааг үндсэн тусламж, үйлчилгээний чиглэлээр энэ удирдамжийн 1.5-д заасан эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

3.2.2.эрт илрүүлгийн тусламж, үйлчилгээний эмнэлзүйн заавар, удирдамжийг ашиглан сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалтад эмч, эмнэлгийн мэргэжилтэн, сургуулийн эмч, сургуулийн эмч, ажилтнуудыг хамруулах ажлыг зохион байгуулах;

3.2.3.онош тодруулахаар илгээсэн тохиолдлыг хүлээн авч, оношийг баталгаажуулах, эмчилгээ, хяналтын зааварчилгаа өгөх, шаардлагатай тохиолдолд мэргэшсэн эмчийн шууд хяналтад авах, эргэн мэдээлэх.

3.3 Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв дараах чиг үүргийг хүлээнэ:

3.3.1.эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлийг үнэлэхэд энэ удирдамжийн 1.5-д заасан багт мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

3.3.2.эрт илрүүлгийн тусламж, үйлчилгээний эмнэлзүйн заавар, удирдамж, гарын авлага, сургалтын хөтөлбөрт санал өгөх;

3.3.3.эрт илрүүлгийн талаарх мэдээллийг сурталчлах нэгдсэн загварыг гаргаж, эрүүл мэндийн байгууллагуудад түгээх, байгууллагын вэбсайт, цахим хуудсанд байршуулах;

3.3.4.эрт илрүүлгийн ач холбогдлыг таниулж, хамрагдахыг уриалсан мэдээллийг шинжлэх ухааны нотолгоонд түшиглэн хүн бүрд ойлгомжтой байхаар боловсруулж, мэдээллийн бүх төрлийн сувгаар хүртээмжтэй түгээх.

3.4 Эрүүл мэндийн хөгжлийн төв дараах чиг үүргийг хүлээнэ:

3.4.1.эрт илрүүлгийг зохион байгуулахад шаардагдах хүний нөөцийг бүрдүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, сургуулийн эмч, ажилтнуудыг чадавхжуулах богино хугацааны сургалтыг улсын хэмжээнд үе шаттай зохион байгуулах;

3.4.2.эмнэлзүйн заавар, удирдамж болон сургалтад ашиглах хичээл, гарын авлагын нэгдсэн санг үүсгэн, байгууллагын веб сайт, цахим хуудсанд байршуулах;

3.4.3.эрт илрүүлгийн тоо мэдээг цуглуулж, чанарын хяналт тавьж, нэгтгэн мэдээлэх;

3.4.4.эрт илрүүлгийн эрүүл мэндийн лавлагаа гаргах нэгдсэн цахим программ хангамжийг хариуцан, шуурхай тасралтгүй байдлыг ханган ажиллах;

3.4.5.цахим системийн сургалтыг эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, сургуулийн эмч, ажилтанд зохион байгуулж, тасралтгүй, тогтмол хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах.

3.5.Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар дараах чиг үүргийг хүлээнэ:

3.5.1.эрт илрүүлэгт ашиглагдах эмнэлгийн хэрэгслийн нэгдсэн худалдан авалт зохион байгуулах, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх.

3.6.Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар дараах чиг үүргийг хүлээнэ:

3.6.1.эрт илрүүлэгт шаардлагатай санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас чанар, төлбөрийн хяналтын шалгуурын дагуу санхүүжүүлэх;

3.6.2.эрүүл мэндийн байгууллагын шатлал тус бүрээр санхүүжилтийг тооцож, жил бүрийн төсвийн төсөл, төсвийн хүрээний мэдэгдэлд тусгахаар санал боловсруулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хуульд заасан хугацаанд хүргүүлэх;

3.6.3.нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран олон нийтэд сурталчлах, халдварт болон халдварт бус өвчлөлийн эрсдэлт хүчин зүйлсийг бууруулахад эрт илрүүлгийн ач холбогдлын талаар эрүүл мэндийн байгууллага болон даатгуулагчдад зориулсан зөвлөгөө, мэдээллийн үйл ажиллагаа зохион байгуулах;

3.6.4.эрт илрүүлгийн санхүүжилтийн талаарх үр дүн, үр ашиг, үр нөлөөний талаарх судалгаа, тооцооллыг хийж, хяналт тавих.

3.7.Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар дараах чиг үүрэг хүлээнэ:

3.7.1.эрт илрүүлгийг зохион байгуулахад харьяалах нутаг дэвсгэрийн хүүхдүүдийг хамруулах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах;

3.7.2.эрт илрүүлгийг үндсэн тусламж, үйлчилгээний хүртээмж, оношилгоо эмчилгээний чанар, аюулгүй байдлыг алдагдуулахгүйгээр зохион байгуулах;

3.7.3.эрт илрүүлгийн мэдээ, мэдээллийн шуурхай, үнэн зөв байдлыг хангаж, тайланг хүлээн авч нэгтгэн, Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргэх;

3.7.4.эрт илрүүлэгт шаардагдах эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл болон бүртгэлийн маягт, цахим программ, хүний нөөцийн хангамж, сургалтын хэрэгцээнд үнэлгээ хийж, жил бүрийн төсөвт суулгах шаардлагатай зардлыг тооцон орон нутгийн болон эрүүл мэндийн салбарын төсвийн төсөлд тусгах саналыг боловсруулж эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх;

3.7.5.анхан шатны эрүүл мэндийн байгууллага, Дүүргийн эрүүл мэндийн төвийг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж, удирдаж, хяналт тавьж ажиллах;

3.8.Аймгийн Эрүүл мэндийн газар, дүүргийн Эрүүл мэндийн төв дараах чиг үүрэг хүлээнэ:

3.8.1.зүрхний эмгэг илрүүлэг үзлэгийн I шатны үйл ажиллагаа буюу зүрхний цахилгаан бичлэг хийх, дүгнэх арга хэмжээг Анхан шатны эрүүл мэндийн байгууллага ба хүүхдийн зүрхний эмч нарын багтай хамтын гэрээ байгуулж, нэгдсэн зохион байгуулалт удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллах;

3.8.2. зүрхний эмгэг илрүүлэг үзлэгийн II шатны үйл ажиллагаа буюу зүрхний хэт авиан оношилгоог хүүхдийн зүрхний эмч нартай гэрээлсний үндсэн дээр нэгдсэн зохион байгуулалт удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллах;

3.9.3. гэрээний хэрэгжилтийг хангуулж, хүүхдийн зүрхний эмч нарыг цалинжуулж ажиллах.

3.9. Анхан шатны эрүүл мэндийн байгууллага дараах чиг үүрэг хүлээнэ:

3.9.1. харьяа нутаг дэвсгэрт байрлах ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн суралцагчдад эрт илрүүлэг үзлэгийн багийг ахалж, зохион байгуулна;

3.9.2. аймгийн Эрүүл мэндийн газар, дүүргийн Эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эмнэлэгтэй гурвалсан гэрээ байгуулж, эрт илрүүлгийн шүдний үзлэгийг зохион байгуулах;

3.9.3. аймгийн Эрүүл мэндийн газар, дүүргийн Эрүүл мэндийн төв Дүүргийн Эрүүл мэндийн төв, хүүхдийн зүрхний эмч нартай гурвалсан гэрээ байгуулж, эрт илрүүлгийн зүрхний үзлэгийг зохион байгуулах. Үүнд Өрх, сум, тосгоны Эрүүл мэндийн төв нь зүрхний цахилгаан бичлэгийг хийх, хүүхдийн зүрхний эмч нар уг зүрхний цахилгаан бичлэгийг дүгнэх байдлаар оролцох;

3.9.4. зүрхний цахилгаан бичлэгт өөрчлөлт илэрсэн буюу II шатны илрүүлэгт хамрагдах шаардлагатай хүүхдийг эргэн мэдээлж, дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран II илрүүлгийг зохион байгуулах;

3.9.5. эрт илрүүлгийн үр дүнд зүрхний эмгэг илэрсэн, анхан шатны Эрүүл мэндийн байгууллагын хяналтад байх шаардлагатай хүүхдийг хяналтад авч, шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэх.

3.10. Шүдний эмнэлэг дараах чиг үүрэг хүлээнэ:

3.10.1. шүдний эрт илрүүлгийг гэрээнд заасан чиг үүргийн дагуу бэлтгэл ажлыг хангах, үзлэг хийх танхим, нэмэлт хэрэглэгдэхүүний бүрэн байдалд хяналт тавих, сургуулийн удирдлагад зөвлөх;

3.10.2. эрт илрүүлгийг үндсэн тусламж, үйлчилгээний хүртээмж, оношилгоо эмчилгээний чанар, аюулгүй байдлыг алдагдуулахгүйгээр зохион байгуулах ба үзлэгийн үед хүүхдийн зан үйлийг залах;

3.10.3. эрт илрүүлгийн үеийн халдвар хамгаалалтын дэглэмийг чанд баримтлах;

3.10.4. амны гаднах болон амны хөндийн эрт илрүүлэг үзлэгийг сургуулийн орчинд хийх, өнгөр тодорхойлох, эрдэсжүүлэх түрхлэгийг түрхэх;

3.10.5. ховил битүүлэгч ломбо тавиулах шаардлагыг хангасан суралцагчдад эмнэлгийн орчинд сийлант тавих;

3.10.6. цахим программд үзлэгийг үр дүнг үзлэгийн өдрөөс хойш 3 өдөрт багтааж оруулах;

3.10.7. сургуулийн эмч болон нийгмийн ажилтанд тайлбар өгөх, сургалт хийх ажлыг зохион байгуулах.

3.10.8. шаардлагатай тохиолдолд шүдний эмчилгээнд хамруулах.

3.11. Орбис интернейшнл олон улсын байгууллага дараах чиг үүрэг хүлээнэ:

3.11.1.нүдний эмгэгийн эрт илрүүлгийн үзлэгийг сургуульд зохион байгуулах нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах.

3.12.Хүүхдийн зүрхний эмч нарын баг дараах чиг үүрэг хүлээнэ:

3.12.1.төлөвлөсөн хугацаанд хуваарийн дагуу зүрхний цахилгаан бичлэгийг уншиж, дүгнэлтийг цахим системд оруулах;

3.12.2.аймгийн Эрүүл мэндийн газар, дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран II шатны илрүүлэг үзлэгийг хийж гүйцэтгэн, дүгнэлтийг цахим системд оруулах;

3.12.3. II шатны илрүүлэг үзлэгт хамрагдсан хүүхдийг хяналтын талаар заавар зөвлөгөө өгч ажиллах.

Дөрөв. Боловсролын байгууллагын чиг үүрэг

4.1.Сургуульд суурилсан эрүүл мэндийн эрт илрүүлгийн үйл ажиллагааг зохион байгуулахад боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Боловсролын ерөнхий газар, аймаг, нийслэлийн боловсролын газар, хэлтэс, ерөнхий боловсролын сургууль энэхүү удирдамжийн 4.2, 4.3, 4.4, 4.5-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх;

4.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь эрт илрүүлгийн цахим бүртгэлийн мэдээллийн санг сургуулийн орчинд баяжуулах, хянах, түүнийг ашиглах үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.3. Боловсролын ерөнхий газар дараах чиг үүрэг хүлээнэ:

4.3.1.батлагдсан удирдамжийг аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэст хүргүүлж, сургуульд суурилсан эрт илрүүлгийн үйл ажиллагааны хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангах;

4.3.2.эрт илрүүлгийн цахим бүртгэлийн системийг сургуулийн орчинд нэвтрүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах;

4.3.3.энэхүү удирдамжийн 2.3-т заасан судалгааг үнэн зөв гаргаж эрүүл мэндийн холбогдох байгууллагад хүргүүлэх;

4.3.4.эрт илрүүлгийн үйл ажиллагааг зохион байгуулахад боловсролын сургалтын байгууллагаас оролцох албан хаагчийг чадавхжуулах сургалт, үйл ажиллагааг холбогдох эрүүл мэндийн байгууллагатай хамтран зохион байгуулах, мэдээллээр хангах;

4.3.5.эрт илрүүлгийн үйл ажиллагааны зохион байгуулалт, үр дүнд суурилан цаашид авах арга хэмжээний санал энэхүү удирдамжийн 3.4, 3.5-д заасан эрүүл мэндийн байгууллагатай хамтран боловсруулах.

4.4.Аймаг, нийслэлийн боловсролын газар/хэлтэс дараах чиг үүрэг хүлээнэ:

4.4.1.харьяа нутаг дэвсгэрт бүртгэлтэй тухайн насны хүүхдийг эрт илрүүлэгт хамруулах үйл ажиллагааг орон нутгийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

4.4.2.эрт илрүүлэг зохион байгуулах хуваарийг ерөнхий боловсролын сургууль бүрээр гаргаж, тэдэнд мэдэгдэх, холбогдох бэлтгэл хангуулах, хяналт тавих;

4.4.3.эрт илрүүлэгт хүүхдийг хамруулах ач холбогдлын талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нөлөөллийн арга хэмжээг эрүүл мэндийн байгууллагатай хамтран тодорхой давтамжтайгаар зохион байгуулах.

4.5.Ерөнхий боловсролын сургууль дараах чиг үүргийг хүлээнэ:

4.5.1.энэхүү удирдамжийн 4.4.2-д заасан хуваарийн дагуу эрт илрүүлгийн үйл ажиллагааг зохион байгуулах бэлэн байдлыг хангах;

4.5.2.тухайн сургууль дээр ажиллаж байгаа эрт илрүүлгийн багт шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэх;

4.5.3.энэхүү удирдамжийн 4.2-д заасан цахим бүртгэлийн системийн хэвийн ажиллагааг хангах интернетийн дэд бүтэц, сүлжээний аюулгүй, тогтвортой байдлыг хангах;

4.5.4.эрт илрүүлгийн үр дүнд үндэслэн эрүүл мэндийн байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмжийн дагуу хүүхдийн эрүүл мэндийг дэмжихэд эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах.

Тав. Эрт илрүүлгийн талаарх мэдээллийн ил тод байдал, эрт илрүүлгийн үр дүнг үнэлэх

5.1.эрт илрүүлгийг бүртгэх, үзлэг шинжилгээний хариу дүгнэлтийг мэдээлэх, эрсдэлтэй тохиолдлыг онош тодруулахаар илгээх, эрүүл мэндийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн зөвлөмжийг өгөх үйлчилгээ бүрэн цахимжсан байна.

5.2.эрт хэрхэн хамрагдах заавар зөвлөгөө, дараалал, алгоритм, эрт илрүүлгийн хариу дүгнэлт, дараагийн шатлалд онош баталгаажуулах тусламж үйлчилгээнд илгээх бичиг, эрүүл мэндийн байгууллагын мэдээллийг цахим, үүрэн утас, хэвлэмэл байдлаар авах боломжоор хангагдсан байна.

5.3.ерөнхий боловсролын сургууль нь энэхүү удирдамжийн талаар суралцагч, тэдний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдийг нээлттэй, ил тод мэдээллээр хангаж ажиллана.

5.4.эрүүл мэндийн даатгалын байгууллага урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн үр дүнгийн талаар дараах мэдээллийг улсын хэмжээнд нэгтгэн цахим хуудсаар нээлттэй мэдээлнэ. Үүнд:

- Эрт илрүүлэгт хамрагдах хүүхдийн тоо;
- Эрт илрүүлэгт хамрагдсан хүүхдийн тоо;
- Зүрхний цахилгаан бичлэгт өөрчлөлт илэрсэн хүүхдийн тоо;
- Зүрхний эмгэг оношлогдсон хүүхдийн тоо
- Зүрхний нээлттэй болон судсан доторх мэс засал хийгдэх хүүхдийн тоо
- Эмчийн хяналтад орж, давтан зүрхний эмгэг илрүүлэх үзлэгт хамрагдах шаардлагатай хүүхдийн тоо
- Хараа өөрчлөлттэй гарсан хүүхдийн тоо /ойрын, холын, стерео/
- Шүдний цооролтой хүүхдийн тоо
- Шүдний гажигтай хүүхдийн тоо
- Шүдээ бүрэн угаадаггүй хүүхдийн тоо

Эрт илрүүлгийн үзлэгийн оролцогч талуудын чиг үүрэг

Оролцогч /хариуцагч	Сургууль дээр үзлэг хийхийн өмнөх бэлтгэл	Сургууль дээр эрт илрүүлгийн үзлэг хийх	Оношилгооны шатны үйл ажиллагаа	Эмчилгээний шатны үйл ажиллагаа	Эрт дараа илрүүлгийн
Сургуулийн захирал	<ul style="list-style-type: none"> • Эрт илрүүлгийн тухай сургуулийн багш, ажилчдад мэдээлэл өгөх. • Сургуулийн үзлэг зохион байгуулах ажлын хэсэг гаргах. • Үзлэгийн үеийн бэлтгэл ажлыг хангасан байх. 	<ul style="list-style-type: none"> • Сургуулийн менежер, нийгмийн ажилтан, эмч болон анги удирдсан багш нарт эрт илрүүлгийн үзлэг хийхэд хамтран ажиллах үүрэг өгөх • Хараа шалгах хэрэглэгдэхүүнээр хангах. 	<p align="center">Эрт илрүүлгийн ерөнхий, нийтлэг зохион байгуулалт</p> <ul style="list-style-type: none"> • Сургуулийн эмч, ангийн багш нарт ЭМЯ-аас санал болгосон шүдний эмнэлэг, нүдний эмнэлэг, хараа зүйн газрын мэдээллээр хангах • Зүрхний эмгэгийн II шатанд хамрагдах шаардлагатай хүүхдүүдийн зохион байгуулалтыг АШЭМБ, ДЭМТ-тэй хамтран идэвхтэй зохион байгуулах 		<ul style="list-style-type: none"> • Эрт илрүүлгийн үзлэгийн тайлантай танилцах, эмч, нийгмийн ажилтан, багш нарыг үүрэгжүүлэх, урамшуулах, компанит ажлыг манлайлан хэрэгжүүлэх, дэмжих.
Сургуулийн менежер болон бусад ажилтан	<ul style="list-style-type: none"> • Үзлэгт хамрагдах нийт хүүхдийн тоог гаргаж, сургуулийн эмчид өгөх. • Сургуулийн ажилчдыг харааны үзлэгт хамруулах • Илрүүлгийн үзлэгийн багийн ажлын төлөвлөгөөг ангийн багш, сургуулийн эмч, сургуулийн нийгмийн ажилтан, АШЭМБ-тай хамтран гаргах 	<ul style="list-style-type: none"> • Үзлэгийн едөр сургуулийн анги танхим, тасалгаа, бүртгэлийг хариуцах /Байгалийн гэрэлтүүлэг сайтай, эрүүл ахуйн шаардлага хангасан байх/ • Хараа шалгах эхний өдөр нүдний эмч авчирч 1-2 цагийн зөвлөгөө, тусалцаа авах хүсэлтээ илэрхийлэх. • Хараа шалгах үеэр цаасан бүртгэл хийж, түүнийгээ тухайн өдөртөө эрүүл хүүхэд бүртгэлийн сан руу оруулах. • Хараа шалгах үзлэгт тэнцээгүй хүүхдийг анги удирдсан багш тус бүрд болон 	<ul style="list-style-type: none"> • Сургуулийн захиргаанаас болгосон шүдний эмнэлэг, нүдний эмнэлэг, хараа зүйн төвүүдтэй холбогдож, тус сургуулиас очих хүүхдийн тоо, мэдээллийг явуулна. • Нүд, шүдний эмчид очиж үзүүлсэн болон үзүүлээгүй хүүхдийн тоог анги, бүлгээр гаргаж тайлагнах. • Нүдний эмчид очиж боломжгүй хүүхдүүдэд зориулж нүдний эмчийн үзлэг зохион байгуулах 	<ul style="list-style-type: none"> • Харааны шил худалдаж авах санхүүгийн боломжгүй хүүхдийн жагсаалт гаргаж, сургуулийн захиргаа болон хараа зүйн төвүүдээс хямд 	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн боловсрол олгох компанит ажил зохион байгуулах • Эрт илрүүлгийн үзлэгийн тайланг хүлээн авч үзлэгийн тайланд үндэслэж хүүхдийг нарийн мэргэжлийн эмчилгээнд илгээх, хянах. • Ховил битүүлэгч ломбо тавиулах тал дээр хяналтыг хангах, мэдээллийг бүртгэх.
Сургуулийн нийгмийн ажилтан	<ul style="list-style-type: none"> • Сургууль эмчгүй бол эмчийн чиг үүргийг хэрэгжүүлэх • Сургууль эмчгүй бол хараа шалгах сургалтад хамрагдаж харааны үзлэг хийх ур чадвар эзэмших 				

<p>Сургуулийн эмч</p>	<ul style="list-style-type: none"> • ЭМЯ, БЯ-наас зохион байгуулах хараа шалгах чадвар эзэмших сургалтад хамрагдах. • Эрт илрүүлгийн бэлтгэл ажлыг хангах, ангийн багшийг мэдээллээр хангах. • Цахим мэдээллийн бүртгэлийн санд нэвтрэх эрх нээлгэж, хүүхдийн бие бялдрын үндсэн үзүүлэлт болох биеийн өндөр жингийн мэдээллийг цахим бүртгэлд бүрэн оруулсан байх, мөн хүүхдийн эрт илрүүлгийн мэдээллийн ангийн багшид дамжуулан өгөх. • Хараа шалгах гарын авлага, видео бичлэг, цаасан бүртгэлийн форм, “Эрүүл хүүхэд” бүртгэлийн санд нэвтэрч орох эрхтэй болох • Илрүүлэгт хамрагдсан хүүхдийн мэдээллийг цахим бүртгэлд оруулах чадварт суралцсан байх; 	<p>нүдний нарийн мэргэжлийн эмчид мэдэгдэх</p> <ul style="list-style-type: none"> • Шүдний үзлэгийн үеэр цаасан бүртгэлийг давхар хийх, хүүхдийг үзлэгт идэвхтэй хамруулах, зан үйлийг залахад туслах. • Шүдний үзлэгт тэнцээгүй хүүхдийг сургуулийн эмч цахим бүртгэлийн сангаас мэдээллийг авч анги удирдсан багш тус бүрд мэдэгдэж шүдний нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх • Үзлэгийн дараа эмчийн өгөх заавар зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хяналт тавин ажиллах • Эмчилгээнд хамрагдсан эсэх мэдээллийг цахим бүртгэлийн мэдээллийн санд оруулах • АШЭМБ, шүдний эмнэлэгтэй хамтран зүрхний цахилгаан бичлэг, шүдний үзлэг хийх хийх бэлтгэл ажлыг ханган, хамтран зохион байгуулах; 	<ul style="list-style-type: none"> • Зүрхний эмгэгийн II шатанд хамрагдах шаардлагатай хүүхдүүдийн зохион байгуулалт АШЭМБ, ДЭМТ-тэй хамтран идэвхтэй зохион байгуулах; 	<p>үнэтэй харааны шил олгох тухай зөвшилцөх</p> <ul style="list-style-type: none"> • Эрт илрүүлгийн үр дүнд лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж үйлчилгээ авах, нүдний шил зүүх, шүдний эмчилгээ шаардлагатай хүүхдийн талаарх мэдээллийг бүртгэх, хянах; 	<ul style="list-style-type: none"> • Шүд цоорох өвчний тархалт 50% дээш байгаа тохиолдолд шүд цоорох өвчний эсрэг идэвхжүүлэх үйл ажиллагааг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх, компани ажлыг зохион байгуулах, тайланг илгээх. • Эмчилгээний хэрэгцээ шаардлагад үндэслэж шүдний эмнэлэгт хандаж эмчилгээ үйлчилгээг авч байгаа эсэхийг хянах • Зүрхний эмгэгийн илрүүлгийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллах; • Зүрхний эмгэг оношлогдсон хүүхдийн хяналтыг Эрүүл мэндийн байгууллагатай хамтран хийх;
------------------------------	---	--	--	--	--

<p>Анги удирдсан багш/туслах багш</p>	<ul style="list-style-type: none"> Асран хамгаалагчдад эрт илрүүлгийн үйл явцын тухай мэдээлэл өгөх, таниулсан зөвшөөрлийг авсан байх. Эцэг эхчүүдээс хүүхдийн эрүүл мэндийн эрсдэлийг үнэлэх асуумжийг авсан байх Шүдний үзлэгийн өдөр хүүхэд бүрийг гэрээсээ өөрийн шүдний сойз болон аягыг бүрэн ирцтэй авчруулах Анги дунд шүлс хаях хувинг бэлдэж тавьсан байх Эрт илрүүлэг хийх өдөр хүүхдүүд хувцсаа өмсөж тайлахад хялбар байх хувцас өмсгөхөд анхаарах Зүрхний эмгэгийн илрүүлгийн II шатанд хамрагдах шаардлагатай хүүхдийн эцэг эхэд мэдээллийг сайтар хүргэж, зүрхний хэт авиан оношилгоонд хүүхдийг эцэг эхийн хамт илгээж, Эрүүл мэндийн байгууллагад дэмжлэг үзүүлэн ажиллах; 	<ul style="list-style-type: none"> Хуваарийн дагуу суралцагчдыг эрт илрүүлгийн үзлэгт хамруулах, зохион байгуулалтай үзлэгт хамруулах. Эрт илрүүлгийн үзлэгт тэнцээгүй суралцагчдын асран хамгаалагчдад нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх шаардлагатайг мэдэгдэх Шүдний үзлэгийн өдөр хүүхэд бүрийг гэрээсээ өөрийн шүдний сойз болон аягыг бүрэн ирцтэй авчруулах Анги дунд шүлс хаях хувинг бэлдэж тавьсан байх Эрт илрүүлэгт суурилан эрүүл мэндийн боловсролыг олгох, сурталчлах, компаниг ажлыг зохион байгуулах 	<ul style="list-style-type: none"> Шүдний үзлэгт тэнцээгүй болон ховил битүүлэгч ломбо тавиулах шаардлагатай хүүхдүүдийг 1 сарын дотор шүдний эмчид үзүүлэх ба хамрагдалтын мэдээллийг бүртгэлийн санд оруулах. Хараа шалгах үзлэгт тэнцээгүй хүүхдүүд 1 сарын дотор нүдний эмчид үзүүлсэн болон үзүүлээгүй хүүхдийн тоог эрүүл хүүхэд бүртгэлийн санд оруулах. Үзүүлээгүй хүүхдийн шалтгааныг тодруулж сургуулийн эмч бүртгэлийг хийх. Зүрхний эмгэгийн II шатанд хамрагдах шаардлагатай хүүхдүүдийн зохион байгуулалт АШЭМБ, ДЭМТ-тэй хамтран идэвхтэй зохион байгуулах; 	<ul style="list-style-type: none"> Нүдний эмчид үзүүлэх, харааны шилний авч зүүх санхүүгийн боломжгүй хүүхдийн жагсаалтыг сургуулийн нийгмийн ажилтан, эмч, менежерт мэдэгдэж сургууль дээр үнэгүй үзлэг зохион байгуулах, нүдний шил олгох тал дээр дэмжлэг хүсэх Зүрхний эмгэгийн оношлогдсон хүүхдийн эмнэлгийн тусламж авсны дараа хичээл нөхөх үйл ажиллагаанд үзүүлэн дэмжлэг хамтран ажиллах; 	<ul style="list-style-type: none"> Асран хамгаалагчдад эрүүл мэндийн эрт илрүүлгийн үзлэгийн үр дүнг түгээх. Сургуулийн эмч эсвэл нийгмийн ажилтнаас мэдээлэл хүлээн авч эмчилгээ шаардлагатай бол шүдний эмнэлэгт хүргүүлэх тал дээр чиглүүлэн анхааран ажиллах Эрт илрүүлэгт үндэслэж эрүүл мэндийн танилцуулах хичээлийг орох Зүрхний эмгэгийн илрүүлгийн үйл ажиллагаанд хамтран оролцох, хяналт тавин ажиллах;
--	--	--	--	--	---

<p>Асран хамгаалагч</p>	<ul style="list-style-type: none"> Таниулсан зөвшөөрлийн/ мэдэгдлийн хуудас дээр гарын үсэг зурах Хүүхдийн эрт илрүүлгийн дүнд үндэслэж эрүүл мэндийн боловсролоо дээшлүүлэх. Хүүхдэд хэвийн бус шинж тэмдэг, зовуурь илэрвэл яаралтай шүдний эмчид хандах 	<ul style="list-style-type: none"> Гэрийн нөхцөлд хүүхдийн шүд угаалтыг хянах, дэмжих, урамшуулах 	<ul style="list-style-type: none"> Хүүхдийг сургуулиас зөвлөсөн шүдний эмнэлэгт очиж шүдний үзлэгт хамруулж ховил битүүлэгч ломбо тавиулсан байх. Дараагийн шатлалын эмнэлэгт үзүүлэх шаардлагатай бол цаг алдалгүй үзүүлж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах Хэрэв хүүхэд тань зүрхний хэт авиан оношилгоонд хамрагдах шаардлагатай талаар мэдээлэл ирсэн бол мэдээллийн дагуу ажлаа зохицуулан дагуу заасан хугацаанд хүүхдээ хамруулах; 	<ul style="list-style-type: none"> Харааны шил эвдэрч гэмтсэн эсвэл хаяж гэсэн тохиолдолд нэн даруй шинэ шил худалдаж авч өгөх. 6 сарын тугамд хүүхдийн харааг шалгуулж байх. Хүүхэд шил зүүхэд тухгүй толгой эргэх, дотор муухайрах шинж тэмдэг ажиглагдвал дахин нүдний эмчид хандаж, харааны шилийг солих. Хэрэв хүүхдэд тань зүрхний эмгэг илэрсэн бол та зүрхний эмчийн заавар зөвлөмжийн дагуу лавлагаа шатлалын эмнэлэгт хандан, тусламж үйлчилгээ авах; 	<ul style="list-style-type: none"> Эрт илрүүлгийн дараах эмчийн өгсөн заавар зөвлөмжийг дагах, эмчилгээ шаардлагатай тохиолдолд эмчилгээнд хамруулах Хүүхдийг шүдний эмчийн зөвлөсний дагуу эмчилгээнд хамруулах, ховил битүүлэгч ломбыг тавиулах хэрэгцээг ойлгож хүүхдийн сэтгэл зүй, зан үйлийг бэлдэж ярилцах, ойлгуулах. Хүүхдэд харааны шилийг эмчийн зөвлөсний дагуу тогтмол зүүх ёстойг ярилцах, ойлгуулах Зүрхний эмгэгийн 2 шатны илрүүлэгт хүүхдээ бүрэн хамруулан, хэрэв хүүхдэд тань зүрхний аливаа эмгэг илэрсэн тохиолдолд хүүхдийн зүрхний эмчийн зөвлөмжийн дагуу Эрүүл мэндийн байгууллагын зохих шатны хяналтад хамрагдах;
--------------------------------	---	--	---	---	---

<p>Шүдний эмч, шүдний эмчийн туслах</p>	<ul style="list-style-type: none"> • Сургуулийн эмч, нийгмийн ажилтан, багш нарт шүдний эрүүл мэндийн боловсролыг олгох, эзэмшүүлэх, түгээмэл тохиолддог шүдний эмгэгийг таних шүдний эмнэлэгт илгээх зааварчилгааг өгөх. • Суралцагчдад шүд угаалтыг заах идэвхжүүлэх 	<ul style="list-style-type: none"> • Гэрээний заалтын дагуу эрт илрүүлгийн үзлэгийн бэлтгэл ажлыг хангах. • Үзлэг хийх багаж, хэрэгсэл хувийн бэлтгэлийг удирдамжид заасны дагуу бэлтгэх. • Шүдний үзлэгийн өмнө сургуулийн эмч, нийгмийн ажилтантай уулзаж шүдний үзлэг хийх танхим, нэмэлт хэрэглэгдэхүүний бүрэн бүтэн байдалд хяналт тавих, зөвлөх. • Үзлэг хийх ёс зүйн хэм хэмжээ, халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлах. • Үзлэг хийх үед хүүхдийн зан үйлийг залах • Шүдний үзлэгийн үеэр цаасан бүртгэлийг давхар хийх. • Амны гаднах болон аман доторх үзлэгийг хийх, өнгөр тодорхойлох, эрдэсжүүлэх түрхлэгийг хийх. • Цахим программд үзлэгийг үр дүнг үзлэгийн өдрөөс хойш 3 өдөрт багтааж оруулах. • Ховил битүүлэгч ломбо тавиулах шаардлага хангасан суралцагчдад эмнэлэгийн орчинд сийлэнт тавих. 	<ul style="list-style-type: none"> • Сургуулийн үзлэгийн үр дүнд ховил битүүлэгч ломбо тавих шаардлагатай хүүхдийн мэдээллийг бүртгэлийн сан руу оруулах. • Дараагийн шатлалын эмнэлэгт үзүүлэх шаардлагатай хүүхдийн мэдээллийг гаргаж илгээх. • Эмчилгээний хэрэгцээнд үндэслэж эмчилгээг хийх, хяналтад авах. 	<ul style="list-style-type: none"> • Бүртгэлийн санд мэдээллийг тогтмол оруулж, шинэчилж байх. • Сургуулийн эмч, нийгмийн ажилтантай байнга холбоотой байх. • Ховил битүүлэгч ломбыг тавиулах нь чухал болохыг сануулан шаардлага хангасан хүүхдүүдийг бүрэн ирцтэйгээр дуудаж хамруулах. • Эмчилгээ шаардлагай хүүхдийг эмчилгээ үйлчилгээг үзүүлж цаашид урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол дуудаж хамруулах.
---	--	---	---	---

<p>Нүдний эмнэлгийн эсвэл хараа зүйн төвийн нүдний эмч</p>	<ul style="list-style-type: none"> • Сургуулийн эмч, нийгмийн ажилтан, багш нарт хараа шалгах чадвар эзэмшүүлэх, түгээмэл тохиолддог нүдний эмгэгийг таних, хараа шалгах хэрэглэгдэхүүнтэй зөв харьцах тухай заах, хүүхдийн хараа шалгах дадлага хийлгэх 	<ul style="list-style-type: none"> • Урьдчилан сэргийлэх сургалтыг сургууль дээр зохион байгуулах. • Сургуулийн эмч болон нийгмийн ажилтанд тайлбар өгөх, сургалт хийх ажлыг зохион байгуулах. 	<ul style="list-style-type: none"> • Хараа шалгах эхний өдөр сургуулийн эмчийн тавьсан хүсэлтийн дагуу очиж хараа шалгах танхим, хэрэглэгдэхүүний бүрэн бүтэн байдал болон зөв шалгаж буй эсэхийг хянаж зөвлөх 	<ul style="list-style-type: none"> • Сургуулийн хараа шалгах үзлэгт тэнцээгүй хүүхдэд нүдний бүрэн үзлэг хийж, харааны шил зүүх шаардлагатай бол харааны шилний жорын мэдээлэл болон бусад мэдээллийг эрүүл хүүхэд бүртгэлийн сан руу оруулах. • Дараагийн шатлалын эмнэлэгт үзүүлэх шаардлагатай хүүхдийг илгээх. • Нүдний эмчид очиж үзүүлэх боломжгүй хүүхдүүдэд зориулж сургууль дээр очиж нүдний үзлэг хийх 	<ul style="list-style-type: none"> • Харааны шилний “Эрүүл бүртгэлийн бүрэн оруулах. • Жорын дагуу харааны шил хийх. 	<ul style="list-style-type: none"> • Сургуулийн харааны үзлэгийн багтай байнга холбоотой байж техник арга зүйн туслалцаа үзүүлж, бүртгэлийн санд мэдээллийг тогтмол оруулж, шинэчилж байх.
<p>Оптотехникч буюу харааны шил хийх мэргэжилтэн (нүдний эмчгүй газрууд)</p>	<ul style="list-style-type: none"> • Суралцагчдад нүдний шилээ хэрхэн зүүх, арчлах тухай мэдээлэл өгөх 		<ul style="list-style-type: none"> • Шаардлагатай тохиолдолд нүдний эмчтэй хамтран сургууль дээр очиж хамт үзлэг хийхэд оролцох (шилний хүрээ сонгуулах, хүрээ тааруулах ба бусад оролцоо) 	<ul style="list-style-type: none"> • Нүдний эмчийн харааны жорын дагуу шил хийх. • Харааны шил эвдэрч гэмтсэн тохиолдолд жорын дагуу дахин шинэ шил хийж өгөх. • Харааны шилний жор бичиж 	<ul style="list-style-type: none"> • Нүдний эмчтэй хамт сургууль дээр очиж, сургуулийн орчинд шил зүүж буй эсэхэд хяналт тавьж, сэтгэл ханамжийн талаар асуулга авах. (харааны шил хийх явцад алдаа гарсан бол дахин шил хийж өгөх) 	

<p>Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч</p>	<ul style="list-style-type: none"> • Сургуулийн багтай хамтран бэлтгэл ажлыг хангах • Нийслэлийн эрүүл мэндийн газрын мэргэжилтэн, сургуулийн эмч, шүдний эмчтэй хамтран эрт илрүүлгийн үзлэг зохион байгуулах төлөвлөгөө гаргаж, багаа манлайлж ажиллах • Зүрхний цахилгаан бичлэг хийх чадавхжуулах сургалтад хамрагдсан байх • Илрүүлэгт хамрагдсан хүүхдийн мэдээллийг цахим бүртгэлд оруулах чадварт суралцсан байх; 	<ul style="list-style-type: none"> • Эрт илрүүлгийн багийн зохион байгуулалтыг хийж, манлайлж ажиллах • Зүрхний цахилгааны бичлэг хийх • Зүрхний цахилгаан бичлэгийг зохих зааврын дагуу хийж, цахим системд илгээсэн байх; • Зүрхний эмгэгийн II шатны илрүүлэгт хамрагдах шаардлагатай хүүхдийн мэдээллийг сургуулийн эмч, багшид илгээж, II шатны илрүүлэгт хамтран ажиллах; 	<ul style="list-style-type: none"> • Зүрхний эмгэгийн II шатанд хамрагдах шаардлагатай хүүхдүүдийн зохион байгуулалт АШЭМБ, ДЭМТ-тэй хамтран идэвхтэй зохион байгуулах; 	<p>өгснөөс хойш 6 сар өнгөрсөн бол нүдний эмчид үзүүлэхийг шаардах</p> <ul style="list-style-type: none"> • Зүрхний эмгэгийн илрүүлгийн үр дүнд лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж үйлчилгээ авах шаардлагатай хүүхдийн талаарх мэдээллийг бүртгэх, хянах; 	<ul style="list-style-type: none"> • Зүрхний эмгэг оношлогдсон хүүхдийн АШЭМБ-д хянагдах шаардлагатай бол тухайн хүүхдийн хяналтыг журмын дагуу хийх;
<p>Эксперт/Хүүхдийн зүрхний эмч/</p>	<ul style="list-style-type: none"> • ЭМЯ-наас зохион байгуулах чадавхжуулах сургалтад хамрагдсан байна; • Илрүүлэгт хамрагдсан хүүхдийн мэдээллийг цахим бүртгэлд оруулах чадварт суралцсан байх; 	<ul style="list-style-type: none"> • Хуваарийн дагуу Дүүргийн Эрүүл мэндийн төв, Аймгийн нэгдсэн эмнэлэг, АШЭМБ-тай гэрээ байгуулж, цахим программд хадгалагдсан зүрхний бичлэгийг 5-7 хоногийн дотор зааврын дагуу хариуцлагатай уншиж, дүгнэнэ. • II шатны илрүүлэгт хамрагдах шаардлагатай хүүхдийн нэрсийг тодорхой болгоно; • Цахим системд зүрхний цахилгаан бичлэгийн дүгнэлтийг оруулах; 	<ul style="list-style-type: none"> • II шатны илрүүлгийн харьяалах дүүргийн эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулах; • Зүрхний хэт авиан оношилгоог зохих журмын дагуу хүүхэд бүрд хийх; • Цахим системд зүрхний хэт авиан оношилгооны дүгнэлтийг оруулах; • Зүрхний эмгэг оношлогдон, лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээнд хамрагдах шаардлагатай хүүхдийн нэрсийг тодорхой болгоно; 	<p>Зүрхний эмгэг оношлогдсон хүүхдийн эцэг эхэд зөвлөгөө мэдээлэл өгч, хянагдах шаардлагатай шатлалыг тодорхойлох;</p> <ul style="list-style-type: none"> • Цахим системд мэдээллийг оруулах; 	<ul style="list-style-type: none"> • Зүрхний эмгэг оношлогдсон хүүхдийн эцэг эхэд зөвлөгөө мэдээлэл өгч, хянагдах шаардлагатай шатлалыг тодорхойлох; • Цахим системд мэдээллийг оруулах;

<p>Дүүргийн Эрүүл мэндийн төв, Аймгийн нэгдсэн эмнэлэг</p>	<ul style="list-style-type: none"> • Хүүхдийн зүрхний эмч нар болон АШЭМБ-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан байх; • Интернет, компьютер, Хүүхдийн датчиктай зүрхний хэт авиан оношилгооны аппаратыг бэлдсэн байх; • Зүрхний эмгэгийн II шатны илрүүлгийн хийх хуваарийг батлуулан, холбогдох байгууллагад мэдэгдэх; 	<ul style="list-style-type: none"> • ЕБС-д зүрхний эмгэгийн II шатны илрүүлэгт хамрагдах шаардлагатай хүүхдийн нэрсийг хүргүүлсэн байх; 	<ul style="list-style-type: none"> • Хүүхдийн зүрхний эмчтэй хамтран зүрхний эмгэгийн II шатны илрүүлэг буюу зүрхний хэт авиан оношилгоог зохион байгуулах; 	<ul style="list-style-type: none"> • Зүрхний эмгэг оношлогдсон хүүхдийн хяналтыг зохих журмын дагуу хийх;
--	---	--	--	--

I.НҮДНИЙ ЭМГЭГИЙН ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ҮЗЛЭГИЙН АРГАЧЛАЛ, ЗУРАГЛАЛ

A.Холын хараа шалгах

Энэхүү тест (#259500 – LEA SYMBOLS® MASS Flipchart Set) нь холын зайнаас харах чадварыг бууруулдаг харааны эмгэгийг илрүүлэх аргачлал юм (жишээ нь хичээлийн танхимын самбарыг харах). Энэхүү шинжилгээ нь миопи (холын хараа муу байх) төдийгүй төрөлхийн болон олдмол нүдний олон төрлийн өвчнийг илрүүлдэг. Холын харааг 3 метрийн зайнаас шалгана.

1. Дүрсээ таниулах

Харааны хүснэгтэд дагалдаж ирдэг жижиг картыг үзүүлэн дүрсүүдийг нэрлүүлнэ.
Жич: Хүүхэд бүр өөрийнхөөрөө нэрлэж болно.

2. Нүдний хаалтыг хэрэглэх

Нүдний хаалт зөв хэрэглэх

- Нүдний хаалтаа зөв барих
- Нүдээ бүтэн хаах
- Нүдний хаалтаар хаасан
- Нүд нээлттэй байх

Түгээмэл гардаг алдаа

- Нүдний хаалтаа авч харах
- Урагш тэмүүлж суух
- Онийж эсвэл хүчилж харах
- Дүрсээ тааж хэлэх

3. Харааны хүснэгтийн дүрсийг зөв заах

- Дүрсийг хүрээлсэн хүрээний **гадна** талаас заана.
- Дүрсийг хүрээлсэн хүрээний **дотор** зааж болохгүй.
- **Тухайн эгнээний бүх дүрсийг уншуулна.**
- Дүрсийг заахдаа хүүхэд нүдээ зөв тагласан эсэхийг хянана.

Холын хараа шалгахад анхаарах зүйлс:

- Хүүхэд хараагаа хэрхэн шалгуулахаа ойлгосон эсэх
- Таны бие, хуруу, үзэг хүснэгтийн үсгийг тагласан эсэх
- Зөв нүдийг нь хааж байгаа эсэх
- Нүдээ зөв хааж байгаа эсэх

B.Ойрын хараа шалгах

Ойрын харааг шалгах аргачлал (#257700 – LEA SYMBOLS® Near Card Line/MASS) нь харааны урьдчилан сэргийлэх үзлэгт нэмэлтээр орсон юм. Энэ нь хүүхэд ойрын зайнд тод харж чадахуйц хараатай эсэхийг үнэлдэг арга юм. Энэ шинжилгээг

хийснээр хүүхдийн унших ба цаашлаад боловсролыг бүрэн дүүрэн эзэмшихэд саад болох харааны эмгэг байгаа үгүйг тодорхойлно. Жишээ нь гиперопи (ойрын хараа муу байх) болон астигматизмыг (нүд босоо хэвтээ тэнхлэгээр өөр хэлбэртэй байх ба гэрэл хугарал хоёр тэнхлэгт өөр байх) оношлоход хамгийн сайн арга юм.

1. Ойрын харааг 40 см зайнаас шалгана.

Хоёр нүдээр зэрэг харуулна. Шил зүүдэг бол шилтэй нь хараа шалгана.

2. Харааны хүснэгтээ ашиглан дүрсээ таниулах

Хүснэгт дээрх дүрсийг зааж болно. Харааны чадалд тохирсон эгнээг зааж бүх дүрсийг уншуулна.

3. Үр дүнгээ илгээх

Тэнцэх: 5-5 эсвэл 5-4 зөв хэлэх

Илгээх: 0, 1, 2, 3 дүрсийг зөв хэлэх

В.Стерео хараа шалгах

Стерео харааны сорил (#101400 – Pass Test 1-ОН) нь хүүхэд хоёр нүдээ хамтад нь хос хараанд ашиглаж байгаа эсэхийг шалгах зориулалттай ба ойрын хараатай адил харааны урьдчилан сэргийлэх үзлэгийн багцад шинээр нэмэгдэж орсон аргачлал юм. Энэ тестийг хийснээр амблиопи буюу мохос хараа (залхуу нүд) болон долир/селер нүд (нүд нь дотогшоо эсвэл гадагшаа болсон) зэрэг өвчнийг илрүүлдэг. Стерео хараа шалгах хэрэглэгдэхүүнийг ашиглахад анхаарах зүйлс:

- Стерео картыг нарны шууд тусгалгүй газар хадгалах.
- Норгож болохгүй.
- Цэвэрлэх шаардлагатай бол хуурай даавуун алчуураар зөөлхөн арчих.
- Карт хэрэглэхээс өмнө гараа угаах шаардлагатай.

1. Инээж буй дүрсийг таниулна

2. Дүрсийг ялгаж буй эсэхийг шалгах

- Инээж буй дүрсийг ялгаж буй эсэхийг 40см зайтай картаа барин 5 удаа энэхүү үйлдлийг давтана.
- Хэрвээ ялгаж байвал тестийг үргэлжлүүлнэ, үгүй бол эмч рүү илгээнэ.

3. 40см зайг хэмжих

Smile буюу инээж буй дүрс хаана байгааг хүүхдээр заалгах Инээж буй дүрсийг 5 удаа үзүүлсний дараа стерео шил зүүлгэх

4. Харааны шилтэй бол

Харааны шилтэй бол стерео шилийг давхарлаж зүүлгэнэ.

- Шил зүүсний дараа стерео тестийн картыг нүдний түвшнээс 10 градус налуу барих
- Нэг удаа харуулахдаа 120 секунд хүртэлх хугацаанд хүлээж болно.
- 5 удаа харуулна. 4 удаа зөв хэлбэл тэнцэнэ.

5. Картаа тэгшхэн барих

Урд хойно нь оруулж болохгүй. Далий барьж болохгүй.

Стерео хараа шалгахад анхаарах зүйлс:

- Өрөөний гэрэлтүүлэг сайн байх
- Карт цэвэрхэн байх
- Харааны шил зүүсэн байвал шилэн дээр нь стерео тестийн шилээ зүүлгэх
- Картаа харааны түвшинд тэгш барих

Г. Хараа шалгахад анхаарах ерөнхий зүйлс

- Хэрвээ зураг авах шаардлагатай бол харааны үзлэгт хамрагдах сургуулийн суралцагчид болон багш нараас зураг, бичлэг хийх зөвшөөрөл авах.
- Харааны үзлэгийг гэрэлтүүлэг сайтай, чимээгүй орчинд хүүхэд бүрд ганцаарчлан зохион байгуулах
- Харааны шалгах хэрэглэгдэхүүнийг бүрэн бүтэн, цэвэр байлгах, сургууль хооронд дамжуулахад хүлээлцэх акт үйлдэх


Нүдний эмгэгийн илрүүлэг хийхэд бэлтгэх зүйлс:

1. Холын харааны хүснэгт
2. Ойрын харааны хүснэгт
3. Стерео харааны хүснэгт
4. 3 метр хэмжих метр
5. Цулгуй хана
6. Харааны хүснэгт заах укаск
7. Гэрэлтүүлэг сайтай чимээгүй орчин
8. Илрүүлгийн үзлэгт орох зөвшөөрөл авах
9. Илрүүлгийн үзлэгт орох хүүхдийн нас, хүйс, регистр, анги, сургуулийн мэдээллийн урьдчилан бэлтгэж зориулалтын хүснэгтэд оруулж хэвлэх
10. Бүртгэл хийх боломжтой нөүтбүүк, интернэт
11. Бүртгэл хийх хүн суух, сандал ширээ

Нүдний эмгэгийн илрүүлгийн зохион байгуулалт:

1. Хүүхэд суух сандал- Зохион байгуулагч сургуулийн ажилтан
2. Бүртгэлийн өртөө-Нэг сандал, ширээ
3. Ойрын хараа шалгах – тэмдэглэл хийх
4. Холын хараа шалгах – тэмдэглэл хийх
5. Стерео хараа шалгах – тэмдэглэл хийх
6. Тайлангийн маягтад оруулж “Эрүүл хүүхэд” бүртгэлийн санд оруулах
7. Нэг хүүхдэд зарцуулах хараа шалгах үзлэгийн хугацаа: 15-20 минут (хол, ойр, стерео хараа, цаасан бүртгэл хийх)

НҮДНИЙ ЭМГЭГИЙН ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ҮЗЛЭГИЙН ЗУРАГЛАЛ



*Хараа шалгах үзлэгт оруулахыг зөвшөөрөөгүй хүүхдийн асран хамгаалагчдад нүдний эрүүл мэндийн боловсрол олгох

II. ШҮДНИЙ ЭМГЭГИЙН ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ҮЗЛЭГИЙН АРГАЧЛАЛ, ЗУРАГЛАЛ

№	Үе шат	Хийгдэх үйл ажиллагаа
1	Сургууль дээр шүд, амны хөндийн эрт илрүүлэг үзлэгийг хийж эрдэсжүүлэх фторт түрхлэг түрхэх	1.Шүд, амны хөндийн өвчлөлийг эрт илрүүлэх, үнэлэх 2.Амны хөндийн эрүүл ахуйн байдалд үнэлгээ өгөх, шүд угаалтыг идэвхжүүлэх 3.Эрдэсжүүлэх фторт түрхлэг түрхэх 4.Эмчилгээний хэрэгцээ, шаардлагыг гаргах
2	Шүдний эмнэлгийн орчинд ховил битүүлэгч ломбо тавих	1.Байнгын 1-р их араа шүдэнд ховил битүүлэгч ломбо тавих
3	Эмчилгээнд илгээх	1.Эмчилгээ шаардлагатай шүдийг эмчлүүлэх 2.Эрт үеийн эмчилгээнд хамрагдах тал дээр хяналтын үйл ажиллагааг эрчимжүүлэх
4	Эрт илрүүлгийн үр дүнд шүд цоорох өвчний тархалт 50% ба түүнээс дээш үнэлэгдсэн сургуулиуд шүд, амны хөндийн эрүүл мэндийг сурталчлах, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох компаниг ажлыг зохион байгуулах	1.Шүд угаалтыг идэвхжүүлэх 2.Шүд угаах цэгийг байршуулах 3.Уралдаан тэмцээн зохион байгуулах
5	Хяналт	1.Эмчилгээнд хамрагдах хүүхдийн нэрсийг сургуулийн эмч гаргаж эмчилгээнд илгээх ба эрүүлжсэн гэсэн бичгийг нэгтгэж, цахим мэдээллийн санд оруулах. 2.Шүдний эмчилгээний амжилт чанарыг улирал бүр үнэлэн гаргана.

Шүд, амны хөндийн эрт илрүүлгийн зураглал:



Хүүхэд бүрд:

1. Амны гаднах үзлэг
2. Амны хөндийн үзлэг
3. ШЦӨ-ний тархалт, эрчмийг үнэлэх
4. Шүд, амны хөндийд түгээмэл тохиолдох бусад өвчний тархалтыг тогтоох
5. Хүүхэд бүрийн шүдний эмчилгээний хэрэгцээг тогтоох
6. Амны хөндийн эрүүл ахуйн байдлыг үнэлэх, өнгөрийг будах
7. Хүүхдийн сойзыг шалгаж шүд угаах хувь хүнд тохирсон зөвлөгөө өгөх
8. Хүүхдийн шүдний сойзыг ашиглаж өнгөрийг цэвэрлэх
9. Хүүхдийн шүдэнд эрдэсжүүлэх фторт түрхлэг түрхэх, зөвлөгөө өгөх
10. Амны хөндийн эрт илрүүлгийн үзлэгийн мэдээллийг цаасан болон цахим бүртгэлээр давхар хийх
11. Эцэг эх, асран хамгаалагчид үзлэгийн тайлан, мэдээллийг хүргэх
12. Эмчилгээний хэрэгцээ шаардлагад үндэслэн байнгын 1-р их араа шүдэнд ховил битүүлэгч ломбыг (сийлант) шүдний эмнэлгийн орчинд тавих
13. Шүдний эмчилгээнд хамрагдах шаардлагатай суралцагчдын мэдээллийг гаргаж, эмчлүүлэх
14. Амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Илрүүлэг эхлэхэд бэлтгэх зүйлс:

Сургуулийн зүгээс:

- Таниулсан зөвшөөрлийн хуудас дээр эцэг ах, асран хамгаалагчийн гарын үсгийг зуруулсан байх
- Анги танхимын бэлтгэл ажлыг хангасан байх /Байгалийн гэрэлтүүлэг сайтай, эрүүл ахуйн шаардлага хангасан байх, шүдний үзлэгийг хэвтүүлж хийх тул үзлэгийн ор эсвэл орлуулах ширээн дээр зөөлөвч бүхий гудас тавьж байршуулсан байх/
- Сургуулийн багш, эмч нарыг татан оролцуулан бүртгэл, зохион байгуулалтыг хангах
- Хичээлийн хуваарийг зохицуулсан байх
- Үзлэгийн өдөр хүүхэд бүрийг шүдний сойз, ам зайлах аягатай ирүүлэх
- Ам зайлах усыг хүүхдийн аяга тус бүрд хийж бэлтгэх, ус асгах хувин, савыг бэлтгэх
- Нойтон, хуурай салфетка (Анги дунд 1 ширхэг байх)

Нүүр амны үзлэг хийх баг, эмнэлгийн зүгээс:

- Сургуулийн хариуцах ажилтантай өмнө нь уулзаж, бэлтгэл ажлыг хангуулах, хамтран ажиллах
- Ажлын хэсэг багаар уулзаж, зохион байгуулалтыг тохирох, төлөвлөгөө гаргах
- Үзлэгийн багаж, хэрэгсэл, материалын бэлтгэлийг хангах
- Үзлэгийн зохион байгуулалтад сургуулийн удирдлага багш, эмч нарыг татан оролцуулах
- Үзлэг хийх үеийн ёс зүйн хэм хэмжээ, халдвар хамгааллын дэглэмийг чанд сахих
- Үзлэгийн үед хүүхдийн зан үйлийг залах

- Шүдний эмнэлгийн орчинд ховил битүүлэгч ломбыг тавих, хүүхдийн шүдний эмчилгээнд шаардагдах материал болон бусад багаж, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангасан байх

Илрүүлэг хийх аргачлал:

Хүүхдийн шүдний үзлэгийг эцэг эх, асран хамгаалагчаас таниулсан зөвшөөрөл авсны дараа байгалийн гэрэлтүүлэг сайтай, эрүүл ахуйн зохих шаардлага хангасан орчинд халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиж, хүүхдэд айдас түгшүүр үүсгэлгүй, сэтгэл зүй, зан үйлийг зөв залан хийж гүйцэтгэхээр зохион байгуулна. Хүүхдийг хэвтүүлэн шүдний үзлэгийг хийхэд ор эсвэл орлуулах ширээн дээр зөөлөвч тавьж бэлдсэн байх ба эмч нэмэлт гэрэлтүүлэг ашиглах шаардлагатай.

Хүүхдийн шүдний үзлэгийг хийхэд шаардлагатай хэрэглэгдэхүүн:

1. Үзлэгийн нэг удаагийн цомог багаж (толь, зонд, тавиур, энгэрэвч, энгэрэвчний хавчаар)
2. Нэмэлт гэрэлтүүлэг (Гар чийдэн, духны гэрэл)
3. Нэг удаагийн үзлэгийн бээлий
4. Гар халдваргүйжүүлэгч гель
5. Үзлэгийн малгай, маск
6. Өнгөр тодорхойлогч уусмал
7. Хөвөн бамбар (өнгөр тодорхойлогч уусмалыг шүдэнд түрхэх)
8. Шүдний сойз, аяга (Хүүхэд өөрийн сойз аягыг авчирсан байх/Мартсан тохиолдолд нэг удаагийн аяга ашиглах)
9. Фторт лак түрхэх иж бүрдэл
10. Үзлэгийг цаасаар болон цахим мэдээллийн бүртгэлийн санд оруулах тул үзлэгийн карт, цэнхэр өнгийн бал, зөөврийн компьютертой байх
11. Эмнэлгийн хог хаягдлын уут
12. Хуурай салфетка анги дунд нэгийг бэлдсэн байх
13. Нүүрний толь

Хүүхдийг өөрт нь эвтэйхэн байрлалаар хэвтүүлж насанд нь тохирсон үг хэллэгийг ашиглан үзлэгийн тухай тайлбарлаж, ойлгуулна. Энгэрэвчийг хүзүүнд зүүн өгч амны гаднах болон амны хөндийн үзлэгийг хийж эхлүүлнэ.

Амны гаднах үзлэг

1. Нүүрний гадна төрх

Хүүхдийн арьсны чийгшил, өнгө, харагдах байдал, илэрхий харагдах хаван хавдар, нүүрний тэгш хэм, тунгалгийн булчирхайн өөрчлөлт, эрүүний үений байдал зэргийг үнэлнэ. Үнэлгээг:

0. Хэвийн 1. Өөрчлөлттэй 9. Тэмдэглээгүй

Хэрвээ өөрчлөлттэй бол доорх сонголтоос тэмдэглэх:

- 1=Өөрчлөлт (Толгой, хүзүү орчимд)
- 2=Өөрчлөлт (Хамар, хацар, эрүү)
- 3=Өөрчлөлт (Уруул орчимд)
- 4=Өөрчлөлт (Уруулын нач, хүрээ хэсэг)
- 5=Дээд, доод уруулын хэвийн бус өөрчлөлт
- 6=Тунгалагийн булчирхайн томролт (толгой, хүзүү орчим)
- 7=Эрүү нүүрний бусад хаван, хавдар

8=Тэмдэглээгүй

2. Тунгалгийн булчирхайн өөрчлөлт

Эмч хүүхдийн урд болон ард зогсон баруун зүүн 2 талд тэгш хэмтэйгээр тэмтрэн тунгалгийн булчирхайнд эмзэглэл, томролт, өвдөлт байгаа эсэхийг үнэлнэ. Үнэлгээг:

0.Хэвийн 1. Өөрчлөлттэй 9. Тэмдэглээгүй

3. Эрүүний үений үзлэг

Эмч долоовор, дунд хуруунуудыг эрүүний үений ойролцоо байрлуулан амыг нээх болон хаах зааварчилгааг өгч баруун, зүүн талд тэгш хэмтэй эрүүний үений өөрчлөлт байгаа эсэх, гацах, эмгэг дуу гарч байгаа зэргийг үнэлнэ. Үнэлгээг шинж тэмдгийн илрэлээр:

0. Илрээгүй 1. Илэрсэн 9. Тэмдэглээгүй

Хэрвээ шинж тэмдэг илэрсэн бол дэлгэрүүлж шинж тэмдгийг тодруулна. Үүнд:

1. Дуу гарах 2. Зовуурилах (тэмтрэлтээр) 3. Ам ангалт хязгаарлагдах (ам ангайлтын зэрэг <30мм)

Амны хөндийн үзлэг

1. Салстын байдалд үнэлгээ өгөх:

Амыг ангайлгаж буйл, салст дээр хаван хавдар, тууралт, өнгөний өөрчлөлт, афт, шалбархай, шарх шархлаа байгаа эсэхийг сайтар харж үнэлнэ. Амны хөндийн салстын үзлэгийг багаж, нэмэлт гэрэлтүүлгийн тусламжтайгаар хийнэ. Үнэлгээг:

0. Эрүүл 1. Өөрчлөлттэй 9. Тэмдэглээгүй

Хэрвээ өөрчлөлттэй бол тэмдэглэл үлдээнэ:

1. Шарх, шархлаа
2. Буйл салстын хурц үхжилт үрэвсэл
3. Мөөгөнцөртөх өвчин
4. Буглаа
5. Үү
6. Афт
7. Бусад
8. Тодорхойлох боломжгүй
9. Тэмдэглээгүй

Илэрч буй байрлалаар:

0=Уруулын шилэм (Vermillion border); 1=Уруулын нач (гадна хүрээ); 2=Уруул;
3=Уруулын хүн хонхор; 4=Завжны салст; 5=Амны ёроол; 6=Хэл; 7=Хатуу, зөөлөн тагнай; 8=Буйл, түүшингийн буйл; 9= Тэмдэглээгүй

2. Уруулын хөвч: Бланчийн сорилоор үнэлгээг өгөх

Эмч үзлэгийн бээлийтэй хуруугаар 2 гарын эрхий болон долоовор хурууны тусламжтай дээд уруулыг дээш сөхөж татахад хөвч бэхлэгдсэн салстын төгсгөл хэсэгт цайрч харагдвал уруулын хөвч богино байгааг илэрхийлнэ. Үнэлгээг:

0. Хэвийн 1.Богино 9. Тэмдэглээгүй

3. Хэлний хөвч:

Хэлний хөвчийг шалгахдаа хэлийг урагш сунгуулан харахад хэлний үзүүр нь татагдаж зүрх хэлбэрийг үүсгэх эсвэл амаа том ангайсан нөхцөлд, хэлний үзүүрийг хоншоорын үүдэн шүдэнд хүргэж чадахгүй байх нь хөвч богино байгааг илэрхийлнэ. Үнэлгээг:

0. Хэвийн 1.Богино 9. Тэмдэглээгүй

4. Шүд цоорох өвчний тархалт, эрчим:

Нэг удаагийн хэрэглээний үзлэгийн цомог багаж, нэмэлт гэрэлтүүлгийн тусламжтайгаар шүдний үзлэгийг баруун дээд араа шүднээс эхлэн зүүн дээд араа шүд, зүүн доод араа шүд, баруун доод араа шүд гэсэн дарааллаар шүд нэг бүрийг үзэж үнэлнэ. Шүдний тэмдэглэгээ хийх хүснэгтэд тэмдэглэл хөтөлнө. Үүнд:

0.Эрүүл 1.Толбо 2.Цоорсон 3.Авхуулсан 4.Ломбодуулсан 5.Цоорлын хүндрэл 6.Ховил битүүлэгч ломбо 7.Сафорайд 8.Ёзоор 9.Хатуу эдийн эмгэг 10.Шүдний гаж хөгжилт 11.Шүдлээгүй

- Шүд цоорох өвчний тархалтын үнэлгээг: Үзлэгт хамрагдсан цоорсон шүдтэй хүүхдийн тоог эрүүл шүдтэй хүүхдийн тоонд харьцуулан хувиар илэрхийлнэ.
- Шүд цоорох өвчний эрчмийн үнэлгээг: Цоорсон (Ц/ц)+Авхуулсан (А)+Ломбодуулсан (Л/л) шүдний нийлбэр үзүүлэлтийг нийт үзлэгт хамрагдсан хүүхдийн тоонд хувааж гаргана.

5. Хатуу эдийн эмгэг: Цоорлын бус гаралтай шүдний хатуу эдийн эмгэг:

Өвчний үнэлгээг:

0. Эрүүл 1. Өөрчлөлттэй 9. Тэмдэглээгүй

Өвчтэй бол сонгох:

1. Флюороз (Шүд толботох өвчин)
2. Гипоплази (Паалангийн дутуу хөгжилт)
3. Эрози (Паалангийн шалбархай)
4. Паалангийн үжжил (Некроз)
5. Паалангийн элэгдэл
6. Бусад

6. Буйлны үрэвсэл:

Эрүүл буйл, салстын өнгө цайвар ягаан, гялалзсан, чийглэг харагддаг бол эмгэг өөрчлөлттэй буйл улайсан, хавдсан, цус гарсан, хавагнасан байдалтай харагдана. Үнэлгээг:

0.Эрүүл 1.Өөрчлөлттэй 9.Тэмдэглээгүй

7. Зуултын байдал

Сүүн шүдний шүд цоорох өвчин, түүний хүндрэлийн улмаас шүдээ эрт алдсанаас шүдний эгнээний нумын урт алдагдаж дараагийн байнгын шүд шүдлэхэд зай тавигдахгүй, шүд бөөгнөрөх, шүдний эгнээний гажиг үүсэх үндсэн шалтгаан болохоос гадна хоншоор, эрүүний өсөлт хөгжилтөд сөргөөр нөлөөлж орсгой, шаймий, зөрмөл гэх мэт эмгэг зуултыг үүсгэдэг. Хүүхдэд шүдээ хазах, зуух зааварчилгааг өгч, уруулыг ярзайлган хацрыг үзлэгийн толиор татан хөндийрүүлж хоншоор эрүүний шүдний харьцаанд Энгелийн ангиллын дагуу үнэлгээг өгнө. Үнэлгээг:

1. Хэвийн 2. Ангилал 1 3. Ангилал 2 4. Ангилал 3

8. Өнгөр тодорхойлох:

Шүд амны хөндийн өвчний үндсэн шалтгаан болох шүдний өнгөрийг хянах нь анхдагч урьдчилан сэргийлэлтийн нэг хэлбэр юм. Хүүхдийн шүдний өнгөр нь цайвар шаргал өнгөтэй, энгийн нүдээр ялгарч харагддаггүй учир зориулалтын өнгөр тодорхойлогч уусмал болон шахмалыг ашиглан өнгөрийг будаж илрүүлсний дараа будагдсан өнгөр, пелликулан бүрхүүлийг арилган цэвэрлэгээ хийж, шүдний гадаргууг цэвэрхэн, гөлгөр болгоно.

Хэрэглэгдэхүүн: Хүүхдийн шүдний өнгөр будагч зориулалтын уусмал, хөвөн бамбар, сойз, нүүрний толь

Хийх аргачлал:

1. Өнгөр тодорхойлогчийг уусмал хэлбэрээр хэрэглэх нь илүү тохиромжтой
2. Үзлэгийн тавиур дээр будагч уусмалаас тасалж авна
3. Хөвөн бамбарын тусламжтайгаар хүүхдийн эрүүний үүдэн бүлгийн шүдний өнгөрийг будна
4. Амыг усаар зайлуулна
5. Өнгөрийг картад тэмдэглэгдсэн онооны дагуу үнэлнэ
6. Шүдний өнгөрийн байдлыг хүүхдэд харуулан тайлбарлаж шүд угаах аргыг заана
7. Өнгөрийг сойзны тусламжтай цэвэрлэнэ
9. Амыг усаар зайлуулна

Амны эрүүл ахуйн хялбаршуулсан индекс - Фёдорова Володкина-ын аргачлалаар эрүүний үүдэн 6 шүдийг өнгөр тодорхойлогч уусмалаар будаж үнэлгээг өгнө. Будагдсан шүдний гадаргуу нь дутуу угаагдаж байгаа хэсэг болохыг хүүхэд, ангийн багшид харуулан тайлбарлаж өнгөрийн индексийн оноогоор үнэлнэ. Үүнд:

1. Өнгөргүй
2. Бага зэрэг өнгөртэй (Цөгцний 1/3-ээс бага хэсэг өнгөрөөр хучигдсан)
3. Дунд зэргийн өнгөртэй (Цөгцний 2/3 хүртэл хэсэг өнгөрөөр хучигдсан)
4. Их хэмжээний өнгөртэй (Цөгцний 2/3 болон түүнээс дээших хэсэг өнгөрөөр хучигдсан)
5. Шүдний бүх гадаргууг хамарсан
6. Тодорхойлох боломжгүй

9. Эмчилгээний хэрэгцээг тооцох:

Хүүхэд бүрд эмчилгээний хэрэгцээг тогтоож шүдийг эрүүлжүүлэх ажлыг эхлүүлнэ. Эмчилгээний хэрэгцээ шаардлагад үндэслэн:

0. Эмчилгээ шаардлагагүй
1. Ховил битүүлэгч ломбо
2. Ломбо
3. Сувгийн эмчилгээ
4. Шүд авалт
5. Яаралтай эмчилгээ шаардлагатай
6. Гажиг заслын эмчилгээ
7. Мэс заслын эмчилгээ
8. Салстын эмчилгээ
9. Мэргэжлийн цэвэрлэгээ шаардлагатай

Шүдний сойзны сонголтод эмч зөвлөгөө өгөх

Дунд зэргийн эсвэл зөөлөн үстэй шүдний сойзыг хүүхдийн онцлогт тааруулан зөвлөнө. Сойзны толгой нь тухайн хүүхдийн хоншоорын 2 үүдэн шүдний өндөр, өргөнтэй тэнцүү хэмжээтэй байна. Шаардлага хангасан сойзны үс арзайж, нумраагүй харагдах ба шүд угаах аргыг насанд нь тохируулан зааж сургана.

Зөв

Буруу



Хүүхдийн шүдийг фторжуулах

Шүдний паалангийн эрдэс алдагдаж эвдэрч гэмтсэнээр шүд цоордог бөгөөд фтор нь энэхүү паалангаас эрдэс алдагдахыг саатуулж, шүдний эргэн эрдэсжих үйл явцыг сайжруулахаас гадна цооруулагч бактериудын идэвхжилийг бууруулдаг. Фтороор баялаг шүдний паалан нь хүчилд илүү тэсвэртэй учраас шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэхэд фторт бэлдмэлийг хэрэглэх нь өндөр ач холбогдолтой тул фторт бэлдмэлийг шүдний гадарга дээр түрхэн, нэвчүүлэх замаар шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлнэ. Зургаа болон түүнээс доош насны хүүхдүүдэд 5% Натрийн фторт лакийг жилд 2 удаа хэрэглэх нь хамгийн тохиромжтой бөгөөд аюулгүй.

Фторт лак, варниш: 5% фтор агуулсан

Фторт лакийг хэрэглэхгүй заалт:

-Хүүхдийн амны салстад шарх, шалбархай болон бусад морфологи элемент тодорхойлогдсон бол

-Амны салстад харшлын шинж тэмдэг илэрсэн бол

-Сүүлийн 3 сарын дотор өндөр тун бүхий (шүдний эмнэлэгт) фторт бэлдмэл хэрэглэсэн бол

Фторт лакийг хэрэглэхээс өмнө анхааруулах зүйлс:

-Лакийг хэрэглэсний дараа түр хугацаанд хүүхдийн шүдний өнгө өөрчлөгдөнө.

-Лак түрхсэний маргааш шүдээ угаахад шүдний өнгө эргээд хэвийн байдалдаа орно.

Фторт лакийг хэрэглэх арга техник:

Хүүхдийн шүдний өнгөрийг өөрийнх нь сойзоор цэвэрлэж амыг сайтар усаар угааж зайлуулна. Шүдийг шүлснээс тусгаарлаж, хуурайшуулсны дараа фторт лакийг бүх шүдний гадаргууд нимгэн түрхэнэ, шүдний гадарга үлдээхээс зайлсхийхэд анхаарна.

Фторт лакийг хүүхдийн шүдэнд түрхсэний дараах зөвлөмж:

-Түрхлэг түрхүүлсний дараа 30 минутын турш хоол идэх, шингэн зүйл уухыг хориглох

-Лак түрхсэнээс хойш 4 цагийн дотор аль болох халуун зүйл ууж идэхгүй, мөн тэр өдөртөө аль болох зажлуургүй хоол хүнс хэрэглэвэл сайн

-Лак түрхсэнээс хойш багадаа 4 цагийн дотор шүдийг угаах болон шүдний утас хэрэглэхгүй, мөн тэр өдөртөө шүдээ угаахгүй байж болно. Лак түрхсэнээс хойш багадаа 3 сарын дотор давтан түрхэх шаардлагагүй.

Хүүхдийн 1-р их араа шүдэнд ховил битүүлэгч тавих

Шүд цоорох өвчинд өртөмхий хэсэг болох шүдний төрөлхийн ховил хонхрыг ховил битүүлэгчээр (сийлант) хаах мэргэжлийн арга. Шүдний төрөлхийн гүн ховил, хонхрыг фтор агуулсан болон агуулаагүй зориулалтын материалаар хааж, шүд цоорох өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулна.

Хэрэглэх заалт:

Байнгын 1-р их араа шүд бүрэн шүдэлсэн ба шүд цоорох өвчинд өртөөгүй тохиолдолд эмнэлгийн нөхцөлд хэрэглэнэ.

Хэрэглэгдэх багаж:

Шүдний үзлэгийн цомог багаж болох амны толь, хямсаа, сэтгүүр, үзлэгийн бээлий, гэрлийн аппарат, удаан эргэлтийн өрмийн хошуу, өнгөр цэвэрлэх багс, өнгөлгөөний бор болон чулуу, резин, хазалтын цаас, хөвөн бөмбөлөг, шүлснээс тусгаарлах хөвөн

Материал: Хуванцар ховил битүүлэгч материал, хүчил, хөвөн бөмбөлөг, өнгөлгөөний паст


Эсрэг заалт: Шүд цоорох өвчин эхэлсэн тохиолдолд.

Хуванцар сийлант тавих арга техник:

1. Тухайн шүдний өнгөрийг өнгөлгөөний паст ашиглан маш сайн цэвэрлэнэ
2. Бүрэн цэвэрлэгдсэн эсэхийг сэтгүүрээр шалгана
3. Амыг усаар угааж, шүдийг шүлснээс тусгаарлаж, халдваргүйжүүлнэ
4. Зориулалтын хүчлээр ховилын дагуу багсаар болон зориулалтын шприцтэй хошуугаар нимгэн цувуулж түрхэнэ.
5. 5-7 секунд болсны дараа түрхсэн хүчлээ даралттай усаар 10-15 секундийн турш шүршиж угаана.
6. Шүлснээс тусгаарлана. Шүдийг зөөлөн үлээлгэж, хуурайшуулна.
7. Зориулалтын шприц бүхий сийлантыг ховил дагуу цувуулан хийгээд үзлэгийн сэтгүүрээр ховилын дагуу урсган, жигдрүүлэн бүх ховилоор тараана. Аль болох зуулт өндөрсгөхгүйгээр тавихыг анхаарна.
8. Гэрлийн аппаратын тусламжтай 3-20 секунд (гэрлийн аппаратын шарах хүчин чадлаас хамаарна) шарж хатууруулна.
9. Шүдний хоршилтыг хазуулж өндөрдсөн эсэхийг шалгаж үзэхээс гадна хоршилтын цаас зуулган шалгана. Хэрэв зуухад өндөр буюу тухайн шүд түрүүлж хоршиж байвал өнгөлгөөний чулуугаар намсгаж тохируулна.
10. Өнгөлгөөг хийнэ.

Жич: Үйлдвэрлэгчийн зааврыг урьдчилан сайтар уншиж танилцах хэрэгтэй.

Шүдний эмгэгийн эрт илрүүлгийн үзлэгийн зураглал



III. ЗҮРХНИЙ ЭМГЭГИЙН ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ҮЗЛЭГИЙН АРГАЧЛАЛ, ЗУРАГЛАЛ

Илрүүлэг эхлэхэд бэлтгэх зүйлс:

Сургуулийн зүгээс:

- Илрүүлэг, үзлэг хийх танхим
- Уртасгагч 3-4 ширхэг
- Хурд сайтай интернэт
- Бүртгэл хийх өртөөнд ширээ 1 ширхэг, сандал 1 ширхэг
- Зүрхний цахилгаан бичлэг хийх үед хүүхдийг хэвтүүлэх тэгш гадаргуутай, зөөлөн дэвсгэртэй ор 1-2 ширхэг
- Гар ариутгагч, хуурай салфетка, хогийн сав шар уутны хамт орны хажууд байршуулах
- Тухайн ангийн хүүхдийн овог нэр регистртэй бүртгэлийн хуудсыг хэвлэж бэлдсэн байх
- Зүрхний бичлэг хийх анги танхим руу хүүхдүүдийг 5,5-аар зохион байгуулан оруулж суулгах
- Хүүхдийг суугаад хүлээх сандал 5-10ш үзлэгийн ширээний хажууд байрлуулах
- Үзлэг хийлгэх үеэр охид дотроо трикогүй ирэхийг багш нар эцэг эхэд сануулах

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын зүгээс:

- Бүртгэл хийх, биеийн өндөр жингийн хэмжилтийн мэдээлэл оруулах зөөврийн компьютер 1 ширхэг
- Хүүхдийн тоогоор нэг удаагийн дэвсгэр
- Эхо-ны гель 2-3ш, жижиг савлагаатай хөвөн / 1 ширхэг хөвөнг 1 хүүхдэд хэрэглэхээр тооцох/
- Хүүхдийн халаасанд түлхүүр гэх мэт төмөр зүйл байлгахгүй байх

Аймгийн нэгдсэн эмнэлэг, Дүүргийн Эрүүл мэндийн төвийн зүгээс:

- Интернэт бүхий компьютер
- Хүүхдийн датчик бүхий зүрхний хэт авиан оношилгооны аппарат

Илрүүлэг хийх аргачлал:

Хүүхдийн зүрхний эмгэгийн илрүүлгийн үзлэгийг эцэг эх, асран хамгаалагчаас таниулсан зөвшөөрөл авсны дараа байгалийн гэрэлтүүлэг сайтай, эрүүл ахуйн зохих шаардлага хангасан орчинд халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиж, хүүхдэд айдас түгшүүр үүсгэлгүй, сэтгэл зүй зан үйлийг зөв залан хийж гүйцэтгэхээр зохион байгуулна.

Зүрхний цахилгаан бичлэг хийх зорилго:

- Бүх насны эрүүл хүүхдэд ЗЦБ-ийн хэвийн үзүүлэлт тогтоох
- Зүрхний эмгэгийг оношлох, ялгах оношлох
- Зүрхний болон бусад эмчилгээг хянах

Заалт:

- Нярай болон бүх насны хүүхдэд онош тодруулах тохиолдол

- Зүрх дэлсэх, зүрх орчмоор өвдлөө гэсэн зовуурьтай бол
- Ачааллын үед амьсгаадаг зовуурьтай бол
- Гэнэт хөхрөх, ухаан алдах зэрэг зовуурьтай бол
- Зүрхний термөл болон олдмол гажигтай бол
- Артерийн даралт хэлбэлздэг бол
- Бөөрний дутмагшил эсвэл суулгалт зэрэг кали хямрах үед
- Гликозид эмчилгээг хянах
- Урьдчилан сэргийлэх үзлэг зэрэг болно.

Эсрэг заалт байхгүй. Харин ачаалалтай бичлэгийг эмчийн заалтаар гүйцэтгэнэ.

Орчин, нөхцөл:

- ЗЦБ-ийн аппаратыг газардуулсан байна.
- Өрөө 20-22°C дулаантай, чимээ шуугиангүй байна.
- Ор газардуулагчтай, хүүхдэд тохиромжтой байх
- Хүүхдийг хооллосноос хойш 2 цагийн дараа бичлэг хийх
- Хүүхдээ дасгаж, тайвшруулсан байна.
- Арьс арчиж цэвэрлэх самбай, физиологийн уусмал, түрхэх гель

Бичлэг үргэлжлэх хугацаа: 2-5 минут

Зүрхний цахилгаан бичлэгийн холболт: ЗЦБ-ийг 12 холболтоор бичих ба хоёр гарын шуу, хоёр хөлийн шилбэнээс холболт хийсэн бичлэгийг стандарт I II III гэх (зураг 12) ба эдгээрээс хүч нэмэгдүүлэн aVR, aVL, aVF гэсэн бичлэг хийнэ.

Дээрх 6 холболтыг мөчний стандарт бичлэг гэнэ. Цээжнээс 6 холболтоор бичлэг хийнэ. Ийнхүү электродийг

- Мөчний
- Цээжний
- Стандарт I холболтыг баруун, зүүн гараас
- Стандарт II холболтыг баруун гар, зүүн хөлөөс
- Стандарт III холболтыг зүүн гар, зүүн хөлөөс

Холболт тус бүрд наад зах нь зүрхний 5-6 хэмнэл тэмдэглэх ба стандарт II холболтод хэмжилт, ажиглалт хийгддэг учир 6-аас доошгүй хэмнэл бичигдэх нь зохистой болно. Хүүхдийн зүрх хэм алдагдалтай тохиолдолд үүнээс ч олон хэмнэл бичих учиртай. Синусын зангилаанаас гарч буй сэрэл нь холболт бүрд өвөрмөц тусгалаа олно. Жишээ нь: синусын зангилаанаас гарсан сэрэл зүрхний урд ханаар тархаж буйг стандарт I холболтод, зүрхний арын ханаар тархаж буйг стандарт III холболтод, харин дээрх хоёр холболтын сэрлийн нийлбэр нь стандарт II холболтод бичигдэнэ. Ийнхүү зүрхний цэнэг тархалтын байршлыг ЗЦБ-ын холболтуудаар тодорхойлж болно (Хүснэгт 1).

ЗЦБ-н холболтууд ба цэнэг тархалтын байршил

ЗЦБ-ын холболтууд	Зүрхний булчингийн хана
I	Зүрхний урд хана
II	I ба III холболтын нийлбэр
III	Зүрхний арын хана
aVR	Зүрхний баруун хажуу хана
aVL	Зүрхний зүүн урд хажуу хана
aVF	Зүрхний арын доод хана
V1 V2	Баруун ховдол
V3	Ховдол хоорондын таславч
V4	Зүрхний орой
V5	Зүүн ховдлын урд хажуу хана
V6	Зүүн ховдлын гадна хажуу хана
V3	Ховдол хоорондын таславч
V4	Зүрхний орой
V5	Зүүн ховдлын урд хажуу хана
V6	Зүүн ховдлын гадна хажуу хана

Зүрхний бичлэгийн технологи

Хүүхдийн ЗЦБ ийн электрод: 12 холболтоор бичихэд 10 электрод ашиглана. Хүүхдэд зориулсан электрод нь хэмжээгээр жижиг байна. 3-8 насны хүүхдэд мөчинд 35x45 мм, цээжинд 25 мм голчтойг тус тус хэрэглэнэ. Хүүхдийн 2 гарын шууны дотор талд электродыг бэхэлнэ. Үүний тулд тухайн орчмын арьсыг самбайгаар арчиж тослоггүй болгосны дараа гель түрхсэн электродыг биеэс хөндийрүүлэлгүй наан, чангалагч боолтоор зөөлөн бооно. Эсвэл наалдах электродыг биед нааж болно.

Мөчний электродод холбосон дамжуулагч кабель нь дараах тэмдэглэгээтэй байна.

- Баруун гарын шуунд- RA-Улаан
- Зүүн гарын шуунд- LA-Шар
- Зүүн хөлийн шилбэнд – LL- Ногоон
- Баруун хөлийн шилбэнд – RL- Хар электрод бэхэлнэ.

Цээжний электродын байршил: Стандарт холболтод мөчдийн цэгүүдийг шулуунаар холбоход адил талт гурвалжин үүсэх ба дунд нь зүрх оршино. Үүнийг Эйнтховены гурвалжин гэнэ.

ЗЦБ-ийн электродын байршил:

RA-Улаан	Баруун гарын шууны дотор талд
LA-Шар	Зүүн гарын шууны дотор талд
RL-Хар	Баруун шилбэний дотор булчинд
LL-Ногоон	Зүүн хөлийн дотор булчинд
V1	Цээжний баруун 4-5-р хавирга өвчүүнд нийлсэн завсарт
V2	Цээжний зүүн талд 4-5-р хавирган завсарт (өвчүүнд залгах цэг)
V3	2 ба 4-р холболтын дунд

V4	Зүүн эгэмний дундаж шугамаар 5-6-р хавирган завсарт 1 ба 2-р цэгээс доош 1 см-т
V5	Зүүн суганы урд шугамаар 4-р цэгийн адил төвшинд
V6	Зүүн суганы шугамаар 4-р цэгийн төвшин

Хүснэгт-2

ЗЦБ-ийн шүд, хэрчим: ЗЦБ нь шүднүүд болон хэвтээ тэнхлэг буюу цахилгаан саармаг шугамын дагуух хэрчим буюу сегмент, интервал, бүрдэл (комплекс)-ээс бүрдэнэ.

- Шүднүүд нь - P, Q, R, S, T
- Тосгуурын агшилт - P
- АВ-дамжуулалт - P Q(R)
- Ховдлын агшилт - QRS, T
- Тэлэлт - Т төгсгөлөөс Р хүртэл

Ховдлын бүрдэлд: Q, T-интервал, энэ бүрдлийн эхний хэсэг нь QRS, T-шүд ба S, T-хэрчим тус тус орно. Зураг 15-д зүрхний дамжуулах тогтолцоогоор цэнэг дамжих агшинд зүрхний бичлэгийн ямар шүд хэрчим бичигдэхийг үзүүлээ.

Хүүхдэд зүрхний цахилгаан бичлэг хийхдээ анхаарах зүйлс:

- Хүүхэд хөдлөх, уйлах зэрэгт бичлэг чанаргүй болох учир аль болохуйц тайван байлгахыг эрмэлзэх хэрэгтэй.
- Хүүхэд тайван, жигд амьсгалж байвал нэн сайн.
- Өрөө хүйтэн үед булчин чангарах тул бичлэгийн чанарт муу нөлөөтэй.
- Гар утас, төмөр агуулсан түлхүүр зэрэг цахилгаанжиж бичлэгийн чанарт нөлөөлж болзошгүй зүйлсийг хүүхдийн биеэс холдуулах шаардлагатай.

Зүрхний цахилгаан бичлэг хийх үйлдлийн дэс дараалал:

1. Хэрэгтэй багаж, хэрэгслийг цуглуулах. Зүрхний цахилгаан бичлэг хийх аппарат болон электродуудыг /холболтуудыг/ бэлтгэх.
2. Сэтгэл зүйг бэлдэх. Хийх гэж буй үйлдлээ тайлбарлаж хэлээд асран хамгаалагчаас зөвшөөрөл авах.
3. Үйлчлүүлэгч /өвчтөний/ мэдээллийг зүрхний цахилгаан бичлэгийн машинд оруулах.
4. Үйлчлүүлэгчийг /өвчтийг/ хэвтүүлээд, асран хамгаалагч эсвэл өөрөөс нь цээжээ гаргахыг хүсэх.
5. Электродуудыг /холболтуудыг/ зөв байрлуулах.
6. Үйлчлүүлэгчийг тайван байх үед гарч ирсэн зүрхний цахилгаан бичлэгийг хэвлэх.
7. Гарсан хариуг эмчид үзүүлэх. Электродуудыг салгахгүй үлдээсэн ч болно.
8. Электродуудыг салгах. Хэрэв наалддаг электрод байвал тусгай салфеткаар арчиж салгана.

I шатны илрүүлэгт зүрхний цахилгаан бичлэгийг дүгнэх хэсэг

№	Асуулт	Хариулт
1	Зүрхний хэмийн үнэлгээ	<input type="checkbox"/> Синусын <input type="checkbox"/> Синусын бус
2	Зүрхний цохилтын тоо	
3	Зүрхний цахилгаан тэнхлэгийн үнэлгээ	<input type="checkbox"/> Хэвийн <input type="checkbox"/> Баруун хазайлттай <input type="checkbox"/> Зүүн хазайлттай
4	P шүдний далайц /тоон үзүүлэлт/	
5	P шүдний үргэлжлэх хугацаа /сек/	
6	P pulmonale	<input type="checkbox"/> Илрээгүй <input type="checkbox"/> Илэрсэн
7	P mitrale	<input type="checkbox"/> Илрээгүй <input type="checkbox"/> Илэрсэн
8	Interval PR /тоон үзүүлэлт, сек/	
9	AV хориг илэрсэн эсэх	<input type="checkbox"/> Илрээгүй <input type="checkbox"/> Илэрсэн
		<input type="checkbox"/> I
		<input type="checkbox"/> II
		<input type="checkbox"/> III
10	Q шүдний гүн	Тоон үзүүлэлт..... <input type="checkbox"/> Хэвийн <input type="checkbox"/> эмгэг
11	Q шүдний үргэлжлэх хугацаа /сек/	Тоон үзүүлэлт <input type="checkbox"/> Хэвийн <input type="checkbox"/> эмгэг
12	R шүдний далайц	Тоон үзүүлэлт <input type="checkbox"/> Хэвийн <input type="checkbox"/> эмгэг
13	S шүдний гүн	Тоон үзүүлэлт <input type="checkbox"/> Хэвийн <input type="checkbox"/> эмгэг
14	QRS үргэлжлэх хугацаа /сек/	
15	Вольтаж	<input type="checkbox"/> Хангалттай <input type="checkbox"/> Хангалтгүй
16	ST сегментийн өргөгдсөн / доошилсон хэмжээ	Тоон үзүүлэлт /мм/..... <input type="checkbox"/> Хэвийн <input type="checkbox"/> эмгэг
17	T шүдний далайц /тоон үзүүлэлт, мм/	
18	T шүдний үргэлжлэх хугацаа /тоон үзүүлэлт, сек/	
19	QT интервал	Тоон үзүүлэлт /сек/.... <input type="checkbox"/> Хэвийн <input type="checkbox"/> эмгэг
20	Ховдлын зузаарал илэрсэн эсэх	<input type="checkbox"/> Илрээгүй <input type="checkbox"/> Зүүний <input type="checkbox"/> Барууны <input type="checkbox"/> Зүүн баруун хоёулаа илэрсэн
21	T шүдний өөрчлөлт илэрсэн эсэх	<input type="checkbox"/> Илрээгүй <input type="checkbox"/> Илэрсэн
		<input type="checkbox"/> V1 дээр эерэг
		<input type="checkbox"/> V1-V4 хүртэл сөрөг
		<input type="checkbox"/> V1-V5 хүртэл сөрөг
		<input type="checkbox"/> V4 дээр сөрөг
22	V1 холболтод R шүд өөрчлөлттэй эсэх / rSR'	<input type="checkbox"/> Илрээгүй <input type="checkbox"/> Илэрсэн
23	Бусад өөрчлөлт илэрсэн эсэх	<input type="checkbox"/> Илрээгүй <input type="checkbox"/> Илэрсэн
		<input type="checkbox"/> Синусын тахикарди
		<input type="checkbox"/> Синусын брадикарди
		<input type="checkbox"/> WPW / Delta wave
		<input type="checkbox"/> Junctional rhythm
		<input type="checkbox"/> Тосгуурын экстрасистол
		<input type="checkbox"/> Ховдлын экстрасистол
		<input type="checkbox"/> QT уртсах хам шинж
		<input type="checkbox"/> Амьсгалын хэм алдагдал
		<input type="checkbox"/> Бусад
24	Зүрхний цахилгаан бичлэгийн дүгнэлт	<input type="checkbox"/> Хэвийн <input type="checkbox"/> Хэвийн бус
25	Хүүхдийн зүрхний эмчийн үзлэг, зүрхний хэт авиан шинжилгээ шаардлагатай эсэх	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй


I шатны илрүүлэгт анхан шатны Эрүүл мэндийн байгууллагын эмч мэргэжилтний оруулах мэдээлэл

№	Асуулт	Хариулт
1	Захын цусны хүчилтөрөгчийн ханамж /%/	...
2	Зүрхний цохилтын тоо
3	Хүүхэд тайван байгаа эсэх	<input type="checkbox"/> тайван байсан <input type="checkbox"/> уйлсан, айсан байсан
4	Зүрхний бичлэг илгээсэн эсэх	<input type="checkbox"/> илгээсэн <input type="checkbox"/> илгээгээгүй

II шатны илрүүлэгт хүүхдийн зүрхний эмч нарын оруулах мэдээлэл

№	Асуулт	Хариулт
1	Зүрхний хэт авиан оношилгооны дүгнэлт	...
2	Зүрхний эмгэг илэрсэн эсэх	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй
3	Зүрхний эмчийн дүгнэлт онош	
4	Зүрхний эмгэгийн эмчилгээ шаардлагатай эсэх	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй
5	Зүрхний нээлттэй болон судсан доторх хагалгаа шаардлагатай эсэх	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй
6	Хяналт хаана хийгдэх эсэх	<input type="checkbox"/> Анхан шатны Эрүүл мэндийн төвд <input type="checkbox"/> Дүүргийн Эрүүл мэндийн төвд <input type="checkbox"/> Лавлагаа шатлалын эмнэлэгт

Зүрхний эмгэгийн илрүүлэг, үзлэгийн зураглал



ЭМЯ- Эрүүл мэндийн яам
 НЭМГ- Нийслэлийн эрүүл мэндийн газар
 АЭМГ- Аймгийн эрүүл мэндийн газар
 ДЭМТ- Дүүргийн эрүүл мэндийн төв
 АШЭМБ- Анхан шатны эрүүл мэндийн байгууллага
 ЕБС- Ерөнхий боловсролын сургууль